

ҮАБЗ-ИЙН СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

**ШИНЭ ЭРИНИЙ ХЯТАДЫН
БАТЛАН ХАМГААЛАХ
ЦАГААН НОМ-2019**

Албан бус орчуулга

2021 оны 10 сар

АГУУЛГА

Нэг. Олон улсын аюулгүй байдлын төлөв	3
Хоёр. Шинэ эрин дэх хятадын хамгаалах шинжтэй батлан хамгаалах бодлого	7
Гурав. Шинэ эрин дэх армийн эрхэм зорилго, зорилтыг биелүүлэх	12
Дөрөв. Шинэчлэгдэж буй хятадын батлан хамгаалах болон арми	18
Тав. Боломжийн, зохистой батлан хамгаалах зардал	27
Зургаа. Хүн төрөлхтний хувь заяаны хамтын цогц байгуулахад идэвхтэй хувь нэмэр оруулах	31
Дүгнэлт	38



ШИНЭ ЭРИНИЙ ХЯТАДЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЦАГААН НОМ-2019

Орчуулсан Д.Дагийсүрэн
ҮАБЗ-ийн ССХ-ийн ОУБНСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

НЭГ. ОЛОН УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВ

Өнөөгийн дэлхий ертөнцөд зуун жилд байгаагүй ихээхэн өөрчлөлт болж байна. Дэлхий олон туйл болж, эдийн засаг даяарчлагдаж, мэдээлэлжсэн нийгэмд амьдарч, соёл олон төрөл болон гүнзгийрэн хөгжиж буй бөгөөд, энх тайван, хөгжил, хамтын ажиллагаа, хамтдаа хожих нь орчин цаг үеийн өөрчлөгдөшгүй чиг хандлага болж байна .

Олон Улсын стратегийн бүтэц ихээхэн өөрчлөгдөж байна

Олон улсын хүчнүүд хурдацтай өөрчлөгдөж, шинээр хөгжиж буй зах зээлтэй улс болон хөгжиж буй улсын хүч нэмэгдэж стратегийн хүчний харьцаа илүү тэнцвэртэй болж байна. Энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлт бол олон улсын нийгэмлэгийн нийтлэг хүсэл эрмэлзэл болсон. Гэвч жанжлах үзэл, хүчирхэг улс төр, нэг талт үзэл нэмэгдэж, бүс нутгийн мөргөлдөөн, орон нутгийн бослого тасралтгүй үргэлжилж олон улсын аюулгүй байдлын систем, дэг журам халдлагад өртөж байна. Олон улсын стратегийн өрсөлдөөн нэмэгдэж байна. АНУ үндэсний аюулгүй байдлын стратеги, үндэсний батлан хамгаалах стратегиа тодорхойлж дангаарших бодлого баримталж, их гүрнүүдийн өрсөлдөөнийг хурцатгаж, цэргийн зардлаа их хэмжээгээр нэмэгдүүлж, цөмийн, сансрын, кибер, пуужингийн довтолгооноос хамгаалах гэх мэт хүчин чадлаа нэмэгдүүлж дэлхийн стратегийн тогтвортой байдалд хохирол учруулж байна. НАТО гишүүнчлэлээ нэмэгдүүлж, Ойрх Дорнод Европын бүс нутагт цэргээ байрлуулж, тогтмол цэргийн сургуулилт явуулж байна. ОХУ цөмийн болон цөмийн бус стратегийг хориглох чадвараа нэмэгдүүлж, стратегийн аюулгүй байдлын орон зай болон өөрийн эрх ашгаа идэвхтэй хамгаалж байна. Европын холбоо өөрийн бие даасан аюулгүй байдлаа хангах үүднээс аюулгүй байдал болон батлан хамгаалахын интеграцийг ахиулсан.

Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын асуудал улам бүр нэмэгдсээр байна.

Олон улсын зэвсгийн хяналт болон зэвсэг хорогдуулах байдалд саад учирч, зэвсгээр өрсөлдөх хандлагатай. Үй олноор хөнөөх зэвсгийн тархалтаас урьдчилан сэргийлэх нөхцөл байдал ээдрээтэй байна. Олон улсын цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмд прагматизм болон давхар стандарт сөргөөр нөлөөлж шинэ шинэ сорилтууд тулгарсаар. Экстремизм, терроризм улам бүр тархаж, кибер, био аюулгүй байдал, далайн дээрэм гэх мэт уламжлалт бус аюул занал гарах болов. Ираны цөмийн асуудлыг шийдвэрлэхэд ээдрээтэй байгаа бөгөөд Сирийн асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх нь амаргүй байна. Улс бүрийн аюулгүй байдлын уялдаа холбоо, хамаарал, харилцан үйлчлэл тасралтгүй нэмэгдэж, аль ч улс үүнийг бие даан шийдвэрлэж чадахгүй бөгөөд хувиа хичээх байдлаар хандаж болохгүй.

Ази, Номхон далайн аюулгүй байдал ерөнхийдөө тогтвортой байна

Ази Номхон далайн улс бүр хамтын нийгэмлэг гэсэн үзэл санаагаар зангидагдаж маргаан зөрөлдөөнөө яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг гол чиглэлээ болгож бүс нутгаа тогтвортой болгохыг зорьж байна. ШХАБ нь эвсэхгүй, сөргөлдөхгүй, гуравдагч этгээд рүү чиглээгүй бүтээлч түншлэлийг бий болгож батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлж бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ загварыг бий болгосон. Хятад-АСЕАН-ны Батлан хамгаалахын сайд нарын албан бус уулзалт, АСЕАН-ны Батлан хамгаалахын сайд нарын өргөтгөсөн хуралдаан нь бүс нутгийн улсуудын цэргийн солилцооны хамтын ажиллагааг нэмэгдүүлж харилцан итгэлцлийг бий болгоход идэвхтэй үүрэг гүйцэтгэв. Бүс нутгийн улсууд эрсдэлтэй асуудлаа зүй зохистойгоор удирдан хянаж буй тул Өмнөд Хятадын тэнгисийн нөхцөл байдал тогтворжиж байна. Бүс нутгийн улсуудын зэвсэгт хүчин, терроризмыг эсэргүүцэх яриа хэлэлцээний механизм улам бүр гүнзгийрсээр байгаа юм. Тэнцвэртэй, тогтвортой, нээлттэй, хүртээмжтэй Азийн онцлогтой аюулгүй байдлын бүтэц улам бэхжиж байна. Дэлхийн эдийн засаг, стратегийн гол төв Ази Номхон далайн бүс нутаг руу чиглэж, Их гүрнүүдийн тоглоомын гол цэг болсон нь тус бүс нутгийн аюулгүй байдалд тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэлээ. Улмаар АНУ их хэмжээгээр цэргээ байрлуулж, цэргийн холбоог бэхжүүлж байгаа нь ээдрээтэй нөхцөл байдлыг нэмэгдүүлж байна. Мөн АНУ Өмнөд Солонгост пуужингаас хамгаалах “ТНААД” систем байрлуулсан нь бүс нутгийн стратегийн тогтвортой байдлыг алдагдуулж, аюулгүй байдлын эрх ашигт ноцтой хохирол учруулж байна. Япон улс цэргийн аюулгүй байдлын бодлогоо өөрчилж, оролцоогоо нэмэгдүүлж, “Дайны дараах систем”-ийг нураахыг хичээн гадагшаагаа чиглэх үйл ажиллагаа ихэсч байгаа нь харагдана. Австрали АНУ-тай цэргийн холбоогоо үргэлжлүүлэн бэхжүүлж, Ази Номхон далайн бүс нутагт цэргийн оролцоогоо нэмэгдүүлж аюулгүй байдлын үйл хэрэгт илүү их үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэж байна.

Бүс нутгийн халуун цэгүүд болон маргаантай асуудлууд байсаар л байна. Тухайлбал, Солонгосын хойгийн асуудал намжсан ч тодорхойгүй зүйлс хэвээр. Өмнөд Азийн нөхцөл ерөнхийдөө тогтвортой ч Энэтхэг, Пакистаны мөргөлдөөн үе үе гарч, Афганистан дахь улс төрийн эвлэрэл, сэргээн босголтын ажил бэрхшээлтэй байна. Зарим улс хоорондын газар нутаг болон далайн эзэмшлийн маргаан, үндэстэн, шашин хоорондын мөргөлдөөн гэх мэт асуудал оршоор байна.

Үндэсний аюулгүй байдалд тулгарч буй аюул заналыг үл тоомсорлож болохгүй

БНХАУ улс төр, нийгмийн тогтвортой байдал, үндэстний эв нэгдлийг үргэлжлүүлэн хадгалсаар байна. Манай улс улсын хүчин чадал, олон улсад нөлөөлөх чадвар, аюулыг эсэргүүцэх чадвар нэмэгдэж хөгжлийн гол стратегийн үедээ байгаа ч гэсэн аюулгүй байдлын олон олон ээдрээтэй аюул занал, бэрхшээлтэй тулгарч байна.

Салан тусгаарлахыг эсэргүүцэх тэмцэл улам эрчимжиж, Тайваний Ардчилсан дэвшилт намын эрх баригчид “Тайванийг тусгаар тогтноулах” санаа өвөрлөж нэг хятадын зарчмыг баримталсан 1992 оны мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзлаа. Тэдний зохион байгуулж буй үйл ажиллагаа нь Тайваний хоолойн энх тайван, тогтвортой байдлын хамгийн том аюул бөгөөд эх орноо энх тайвнаар нэгтгэхэд саад болж буй хамгийн том аюул занал юм. Үүнээс гадна Төвөдийн тусгаар тогтнол, Зүүн Туркистан гэх мэт салан тусгаарлах хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа улсын аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдалд аюул учруулж байна.

Мөн улсын газар нутгийн аюулгүй байдалд аюул тулгарч, газар нутгийн болон далайн хил хязгаарын асуудал маргаантай хэвээр байгаа юм. Гадаад улсын хөлөг онгоц Хятадад тагнуулын үйл ажиллагаа явуулах, Хятадын газар нутагт харьяалагддаг далай болон арлуудын агаарын орон зайд олон удаа хууль бусаар халдаж буй нь БНХАУ-ын аюулгүй байдлыг хохироож байна.

Хятадын хилийн чанад дахь ашиг сонирхол олон улсын болон бүс нутгийн үймээн самуун, терроризм, далайн дээрэм бодит аюул заналтай тулгарч байгаа бөгөөд гадаадад байгаа байгууллага, аж ахуй нэгжүүд болон ажилчид удаа дараагийн халдлагад өртөж байна. Сансрын болон кибер аюулгүй байдалд заналхийлэх байдал олширч, байгалийн гамшиг, цар тахал зэрэг уламжлалт бус аюулгүй байдлын асуудлын хор хөнөөл ихээр нэмэгдсэн.

Олон Улсын цэргийн өрсөлдөөн улам ширүүсч байна

Дэлхийн томоохон улс орнууд аюулгүй байдлын болон цэргийн стратеги, цэргийн байгууллагын бүтцээ өөрчлөн, байлдааны хүчин чадлаа нэмэгдүүлж, цэргийн өрсөлдөөний стратегиа дээшлүүлэхийг эрмэлзэж байна. АНУ цэргийн харьцангуй давуу байдалтай болохын тулд цэргийн техник болон системээ шинэчилсэн. ОХУ “Шинэ дүр төрх” цэргийн шинэчлэлийг гүнзгий хөгжүүлж, Англи, Франц, Герман, Япон, Энэтхэг гэх мэт улсад цэргийн хүчний системээ сайжруулж байна.

Шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн хувьсгалын явцад хиймэл оюун ухаан, квант мэдээлэл, их өгөгдөл, үүлэн тооцоолол /cloud computing/, юмсын интернэт /internet of things/ гэх мэт дэвшилтэт технологийг цэргийн салбарт хэрэглэж байгаа нь олон улсын цэргийн өрсөлдөөнд түүхэн өөрчлөлтийг бий болгосон. Мэдээллийн технологид суурилсан цэргийн өндөр технологи нь өдөр ирэх тусам хурдтай өөрчлөгдөж байна. Алсын зайн нарийвчлалтай, ухаалаг, нууц, нисгэгчгүй зэвсэг, техник гол чиг хандлага болж байгаа бөгөөд дайн байлдааны хэлбэр нь мэдээллийн болон хувирч ухаалаг дайн эхэлж байна.

Хятадын онцлогтой цэргийн шинэчлэлд ихээхэн дэвшил гарсан боловч механикжсан хоцрогдонгуй байдал байсаар л байна. Тиймээс мэдээлэлжүүлэлтийг түргэсгэх шаардлагатай байна. Хятадын цэргийн аюулгүй байдал нь технологийн довтолгоо, технологийн хоцрогдсон байдлын аюултай тулгарч байна. Цэргийн шинэчлэлийн түвшинг улсын аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхэд дутмаг байгаа бөгөөд дэлхийн тэргүүлэх цэргийн түвшинтэй харьцуулахад маш их ялгаа байсаар байна.



ХОЁР. ШИНЭ ЭРИНИЙ ХЯТАДЫН ХАМГААЛАХ ШИНЖТЭЙ БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО

Хятадын социалист улсын шинж чанар, энх тайванч хөгжлийн замаар явах стратегийн сонголт, бие даасан, энх тайванч гадаад бодлого, эв найрамдлыг эрхэмлэсэн Хятадын соёлын уламжлал нь Хятад улс хамгаалалтын шинжтэй батлан хамгаалах бодлогыг тууштай дагаж мөрдөж буйг тодорхойлдог.

Үндэсний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгаа тууштай хамгаалах

Энэ нь шинэ эрин үеийн Хятадын батлан хамгаалах бодлогын үндсэн зорилго юм.

Хятадын үндэсний батлан хамгаалах бодлогын зорилгууд:

- Түрэмгийллийг таслан зогсоох;
- Улсынхаа улс төрийн аюулгүй байдал, ард түмнийхээ аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалах;
- Тайваний тусгаар тогтнолыг эсэргүүцэх;
- Төвөдийн тусгаар тогтнол, Зүүн Туркистан байгуулах зэрэг салан тусгаарлах хөдөлгөөнийг дэмжигчдийг таслан зогсоох;
- Үндэсний бүрэн эрхт байдал, нэгдмэл байдал, газар нутгийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хамгаалах;
- Хятадын далайн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- Хятадын сансрын, цахилгаан соронзон, кибер орон зай дахь аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах;
- Хилийн чанад дахь Хятадын ашиг сонирхлыг хамгаалах;
- Улсынхаа тогтвортой хөгжлийг дэмжих явдал юм.

Хятад улс үндэсний бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа тууштай хамгаална. Өмнөд Хятадын тэнгис, Диао Ю арал болон түүний харьяа арлууд нь Хятадын уугуул нутаг юм. Хятад улс Өмнөд Хятадын тэнгисийн Жу аралд дэд

бүтцийн бүтээн байгуулалт хийж, шаардлагатай хамгаалалтын хүчийг байршуулсан, Зүүн Хятадын тэнгис дэх Диао Ю арлын хүрээнд эргүүлийн ажиллагаа явуулсан гэх мэт үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу үндэснийхээ бүрэн эрхт байдлаа хамгаалж буй явдал юм.

Хятад улс холбогдох маргааныг түүхэн баримтыг хүндэтгэн, олон улсын хуулийг үндэслэн тухайн улстай шууд яриа хэлэлцээ, зөвлөлдөх замаар шийдвэрлэхийг эрмэлздэг. Мөн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалж, олон улсын хууль тогтоомжийн дагуу бүх улс орон усан болон нислэгийн эрх чөлөөгөө эдлэх эрхийг хангаж, далай дээрх сувгуудын аюулгүй байдлыг хамгаалахад бүс нутгийн орнуудтай хамтран ажиллана.

Тайваний асуудлыг шийдэж, үндэстнээ бүрэн нэгтгэх нь Хятад үндэстний язгуур ашиг сонирхол бөгөөд Хятад үндэстний агуу сэргэн мандалтыг бий болгох зайлшгүй шаардлага юм.

Хятад улс энх тайвнаар нэгдэх, нэг улс, хоёр систем зарчмыг баримталж, хоёр эргийн харилцааг энх тайвнаар хөгжүүлэхийг дэмжиж, Хятадын энх тайвнаар нэгдэх үйл явцыг урагшлуулж, Хятадыг хагалган бутаргах гэсэн аливаа оролдлого, үйлдлийг тууштай эсэргүүцэж, аливаа гадаадын хүч Хятадын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохыг тууштай эсэргүүцнэ. Хятад улс нэгдэх ёстой, зайлшгүй нэгдэнэ. Хятад улс улсынхаа бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хамгаалах онцгой чадвар, шийдмэг зориг төгөлдөр бөгөөд хэн ч, аль ч байгууллага, улс төрийн нам хэзээ ч, ямар ч хэлбэрээр Хятадын газар нутгийн аль ч хэсгийг Хятадаас салгахыг хэрхэвч зөвшөөрөхгүй.

Бид зэвсэг хэрэглэхээс татгалзах амлалт өгөхгүй бөгөөд шаардлагатай бүх арга хэмжээг авна. Энэ нь гадны хүчнүүдийн хөндлөнгийн оролцоо болон хэдхэн Тайваний тусгаар тогтнолыг дэмжигч салан тусгаарлагчид болон салан тусгаарлах хөдөлгөөнийг дэмжигчид рүү чиглэж буй бөгөөд Тайваний нутаг нэгтнүүд рүү чиглээгүй болно. Хэрвээ хэн нэг нь Тайванийг Хятадаас салан тусгаарлуулбал Хятадын арми ямар ч үнээр хамаагүй шийдэмгийгээр ялж эх орныхоо нэгдлийг хамгаална.

Хэзээ ч эзэрхийлэхгүй, нөлөөний хүрээгээ тэлэхгүй

Энэ бол шинэ эриний Хятад улсын батлан хамгаалахын онцлог шинж юм.

Улс орон агуу том байлаа ч дайчид үхэх болно. Хятад үндэстнүүд эртнээс энх тайвныг эрхэмлэж ирсэн. Хятадын ард түмэн 1840-1911 онд түрэмгийлэл, дайн дажинд нэрвэгдэж, энх тайван, хөгжил дэвшлийн үнэ цэнийг гүн гүнзгий ухаарч, мэдэрсэн болохоор туулсан эмгэнэлт туршлагаа бусдад тулгахгүй. Шинэ Хятад улс байгуулагдсанаас хойших 70 гаруй жилд Хятад улс өөрийн санаачилгаар ямар ч дайн байлдаан, үймээн самуун өдөөгөөгүй. Шинэчлэл, нээлттэй бодлого хэрэгжүүлснээс хойш Хятад улс дэлхийн энх тайвныг ахиулахыг эрмэлзэж дөрвөн сая цэргээ санаачилгаараа цомхотгосон. Хятад улс ядуу, сул дорой хөгжлөөс дэлхийн хоёр дахь том эдийн засаг болтлоо хөгжсөн явдал нь бусдын тусламжид тулгуурлаагүй, цэргийн тэлэлт, колончлол дээрэм явуулсан бус харин ард түмний шаргуу хөдөлмөр,

энх тайвныг сахин хамгаалсны үр дүн юм.

Хятад улс дэлхийн энх тайвныг сахин хамгаалах замаар өөрийн хөгжлийн таатай нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй өөрийн хөгжлөөр дамжуулан дэлхийн энх тайвныг ахиулсан юм.

Дэлхийн бусад улс орон ч мөн адил энх тайвнаар хөгжих замыг сонгож дайн байлдаан, мөргөлдөөнөөс хамтдаа сэргийлнэ гэдэгт найдаж байна.

Хятад улс энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг үндэс болгон бусад улс оронтой найрсаг хамтын ажиллагаа хөгжүүлж, ард түмэн нь хөгжлийнхөө замыг бие даан сонгох эрхийг хүндэтгэж, олон улсын маргаантай асуудлыг эрх тэгш яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэхийг дэмжиж, бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэх, өөрсдийн хүсэл санаагаа бусдад хүчээр тулгахыг эсэргүүцнэ.

Хятад улс аливаа цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, түрэмгийллийг эсэргүүцэж, зэвсэг хэрэглэх, зэвсгийн хүчээр заналхийлэхийг эсэргүүцнэ. Хятадын батлан хамгаалахын бүтээн байгуулалт болон хөгжил нь өөрийн улсын аюулгүй байдал болон хууль ёсны шаардлагыг хангах төдийгүй дэлхийн энх тайвны хүч чадлыг нэмэгдүүлэхэд оршиж буй юм. “Хүчирхэг улс зайлшгүй жанжлах бодлого явуулдаг” гэсэн үзлийг халж Хятад улс жанжлах замаар явахгүй гэдгийг түүх нотолсон цаашдаа ч нотолсоор байх болно.

Ирээдүйд хэдий өндөр хөгжилд хүрсэн ч Хятад улс аль нэг улсыг заналхийлэхгүй, хүчээр нөлөөллийн хүрээгээ бий болгохгүй.

Шинэ эрин үеийн цэргийн стратегийн чиг шугамыг хэрэгжүүлж байна

Энэ бол шинэ эрин үеийн Хятадын батлан хамгаалах стратегийн удирдамж юм.

Шинэ эриний цэргийн стратегийн удирдамж нь батлан хамгаалах, өөрийгөө хамгаалах, цохилтын дараах хариу арга хэмжээ авах зарчмуудыг баримталж, идэвхтэй хамгаалалтыг хэрэгжүүлдэг.

Шинэ эриний цэргийн стратегийн удирдамжийг хэрэгжүүлж, Хятадын зэвсэгт хүчин Хятадын Коммунист нам (ХКН) болон тус улсын ерөнхий стратегитай уялдуулж, хувь нэмэр оруулахыг эрмэлзэж, үндэсний аюулгүй байдалд цогц хандлагыг баримталж, мэдлэгийг бэхжүүлж байна. Болзошгүй аюул, хямрал, дайн дажин, шинэ эрин үед даалгавраа үр дүнтэй биелүүлэхийн тулд стратегийн өрсөлдөөний шинэ орчин, үндэсний аюулгүй байдлын шинэ шаардлага, орчин үеийн дайны шинэ хөгжилд идэвхтэй дасан зохицох хэрэгтэй.

Тус улсын өмнө тулгараад буй аюулгүй байдлын заналхийлэлд хариу арга хэмжээ авахын тулд Хятадын зэвсэгт хүчин шинэ эриний цэргийн бэлэн байдлыг бэхжүүлж, байлдааны чадавхаа цогцоор нь нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч байна.

Цэргийн стратегийг батлан хамгаалах асуудалд чиглүүлж, шинэ эриний тэнцвэртэй, тогтвортой стратеги болгохоор хүчин чармайлт гаргасаар байна. Хятадын үндэсний батлан хамгаалах нь бүх Хятадын ард түмний үүрэг хариуцлага

юм гэсэн үзэл санаан дээр үндэслэн Хятадын зэвсэгт хүчин өөрийн стратеги, тактик, үйл ажиллагаагаа шинэчилж, ард түмний дайны ерөнхий хүч чадалд бүрэн үүрэг гүйцэтгэдэг.

Хятад улс хэзээ ч, ямар ч нөхцөлд цөмийн зэвсэг түрүүлж хэрэглэхгүй, цөмийн зэвсэггүй бүс, цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг ашиглахгүй, ашиглахаар заналхийлэхгүй байх цөмийн бодлогыг тууштай баримтална. Хятад улс цөмийн зэвсгийг бүрэн хориглож, бүрэн устгахыг дэмжиж байна. Хятад улс цөмийн зэвсгийн өрсөлдөөнд оролцдоггүй бөгөөд цөмийн чадавхыг үндэсний аюулгүй байдалд шаардагдах хамгийн доод түвшинд байлгадаг.

Хятад улс өөрийгөө хамгаалах цөмийн стратеги баримтлах бөгөөд энэ нь бусад улс орныг Хятадын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх эсвэл ашиглахаар заналхийлэхээс урьдчилан сэргийлж буй явдал юм.

Хятадын онцлогтой хүчирхэг армийг байгуулах явцыг үргэлжлүүлнэ

Энэ бол шинэ эриний Хятадын батлан хамгаалахын хөгжлийн зам юм.

Олон улсын хөгжлийн чиг хандлага, үндэсний аюулгүй байдал болон хөгжлийн ашиг сонирхолд нийцсэн батлан хамгаалах болон хүчирхэг армийг бий болгох нь Хятадын социалист нийгмийг орчин үежүүлэх стратегийн үүрэг, энх тайванч хөгжлийн замаар замнах аюулгүй байдлын баталгаа, мөн түүхийн туршлагаа нэгтгэн дүгнэх зайлшгүй сонголт юм.

Шинэ эрин үеийн Хятадын Батлан хамгаалах, цэргийн байгуулалтын стратегийн зорилго нь

- 2020 он гэхэд өргөн хүрээнд мэдээлэлжих, стратегийн чадавхаа сайжруулах замаар бүрэн механикжих;
- Цэргийн онол, байгуулалт, алба хаагч, байлдааны зэвсэг, техникийн иж бүрэн шинэчлэлийг улс орны хөгжил дэвшилттэй хөл нийлүүлэн урагшлуулж, 2035 он гэхэд цэрэг, батлан хамгаалах салбарын шинэчлэлийг бүрэн хэрэгжүүлж дуусгах;
- XXI зууны дунд үе гэхэд Зэвсэгт хүчнийг дэлхийн жишигт хүргэх ажлыг бүрэн гүйцэлдүүлэх зэрэг болно.

Хүн төрөлхтний хувь заяаны хамтын цогц байгуулахад үйлчилнэ

Энэ бол шинэ эриний Хятадын батлан хамгаалах бодлогын дэлхийн хэмжээний ач холбогдол юм. Хятад иргэдийн мөрөөдөл дэлхийн иргэдийн мөрөөдөлтэй ижил юм. Энх тайванч, тогтвортой, цэцэглэн хөгжсөн Хятад улс бол дэлхийн хувьд боломж, ач тус юм.

Хятадын хүчирхэг арми бол дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах, хүн төрөлхтний хамтын нийгэмлэгийг байгуулахад үйлчлэх хүч юм.

Хятадын арми олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж харилцан ашигтай хамтын ажиллагааны далбааг өндөрт өргөж, өөрийн хүчин чадлын хэмжээгээр олон улсын нийгэмлэгт аюулгүй байдлын бүтээгдэхүүн нийлүүлж, олон улсын энхийг сахиулах ажиллагаа, тэнгисийн цэргийн хамгаалалт, хүмүүнлэгийн

аврах ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын зэвсгийн хяналт, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх хамтын ажиллагааг бэхжүүлж, дэлхийн халуун цэгүүдийн асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэхэд бүтээлчээр оролцож, олон улсын сувгуудын аюулгүй байдлыг хамтран хамгаалж, терроризм, кибер аюулгүй байдал, байгалийн томоохон гамшиг гэх мэт дэлхийн хэмжээний сорилтуудад хамтран хүчин чармайлт гаргаж хүн төрөлхтний хамтын нийгэмлэг байгуулахад идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

ГУРАВ. ШИНЭ ЭРИН ҮЕИЙН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ БИЕЛҮҮЛЭХ

Шинэ эрин үед Хятадын арми үндэсний аюулгүй байдал, хөгжлийн стратегийн шаардлагын дагуу нам, ард түмний өгсөн үүрэг даалгаврыг тууштай биелүүлж, Хятадын Коммунист намын удирдлага, социалист системийг бэхжүүлж, үндэсний бүрэн эрхт байдал, эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад стратегийн дэмжлэг үзүүлнэ. Улсын хилийн чанад дахь ашиг сонирхлыг хамгаалах, дэлхийн энх тайван, хөгжлийг дэмжихэд стратегийн дэмжлэг үзүүлнэ.

Улсын газар нутгийн бүрэн эрхт байдал болон далайн эрхийг хамгаалах

Хятад улсын хуурай газрын хил хязгаар нь 22 мянга гаруй км, далай эргийн хил хязгаар нь 18 мянга гаруй км юм. Хятад улс нь хамгийн олон хөрш оронтой, хамгийн урт хуурай газрын хилтэй, далайн аюулгүй байдлын орчин хамгийн ээдрээтэй орны нэг. Газар нутгийн бүрэн эрхт байдал, далайн эрх, ашиг сонирхлоо хамгаалж улсаа нэгтгэх нь хүнд хэцүү даалгавар юм. Хятадын арми хилийн аюулгүй, тогтвортой байдлаа хамгаалахын тулд халдлага түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаатай идэвхтэй тэмцэж байна. Хятад эргэн тойрныхоо есөн улстай хил хамгаалах гэрээ байгуулж, 12 улстай хил хамгаалах яриа хэлэлцээний механизмыг байгуулсан. Хятадын зэвсэгт хүчин хөрш орнуудтайгаа батлан хамгаалах яам, театрын командлал, хилийн цэрэг гэсэн гурван түвшний механизмыг байгуулсан. Тэд найрсаг харилцан айлчлал, ажлын уулзалт, хамтарсан эргүүл, сургуулилт зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Казахстан, Киргизстан, Орос, Тажикистан улстай хилийн зэвсэг хураах гэрээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хятад Энэтхэгийн хилийн хамгаалалтыг тогтворжуулах үүднээс Дунлан дахь сөргөлдөөнийг энх тайвнаар зохицуулах, таатай нөхцөлийг бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээ авсан. Хятад Афганистаны хилийн хяналтыг чангатгаж, террористууд нэвтрэхээс урьдчилан сэргийлж хамгаалалтыг сайн хийсэн. Хил орчмын бүс нутгийн амар амгалан байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс Хятад Мьянмарын хилийн аюулгүй байдлын хяналтыг чангатгасан. 2012 оноос Хятадын

хил хамгаалах алба хөрш орнуудын цэргийн армитай хамтарч 3300 удаагийн хамтарсан эргүүл хийж, 8100 удаагийн хил хамгаалах хурлыг зохион байгуулсан. Хятад-Вьетнам, Хятад-Мьянмарын хилийн ойролцоогоор 58 хавтгай дөрвөлжин км газарт тэсрэх бөмбөг цэвэрлэх ажиллагаа явуулж, 25 хавтгай дөрвөлжин км талбайг хааж, 170 мянган тэсрэх төхөөрөмжийг илрүүлэн устгасан.

Зүүн болон Өмнөд Хятадын тэнгис, Шар тэнгисийн бүс дэх чухал ач холбогдолтой далайн бүс нутаг болон арлуудын хамгаалалтыг бэхжүүлж, далайн эргэн тойрны нөхцөл байдлыг хараандаа авч, далай тэнгист эрхээ хамгаалж хууль сахиулах үйл ажиллагааг явуулж, агаар болон далайн нөхцөл байдлыг зохистой шийдвэрлэж, далайн аюулгүй байдалд заналхийлж буй зөрчил, өдөөн хатгалгад тууштай хариу өгч байна. 2012 оноос хойш байлдааны хөлөг онгоцоор 4600 удаагийн урьдчилан сэргийлэх эргүүлийн ажиллагаа, эрхээ хамгаалж хуулийг сахиулах ажиллагааг 72 мянган удаа зохион байгуулж далайн энх тайван, амар тайван байдал, дэг журмыг хамгаалав.

Агаарын довтолгооноос хамгаалах, агаарын орон зайд тагнуул, тандалт явуулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, улсынхаа болон эргэн тойрны агаарын байдалд хяналт тавьж, агаарын эргүүл, байлдааны нислэг, агаарын аюулгүй байдлын төрөл бүрийн заналхийлэл болон гэнэт бий болох нөхцөл байдлыг үр дүнтэй зохицуулж, агаарын дэг журам, аюулгүй байдлыг хамгаалж байна. Үндэсний нэгдлийг хамгаалахад чиглэсэн Хятадын зэвсэгт хүчин далайд анхаарлаа төвлөрүүлэн цэргийн бэлэн байдлыг бэхжүүлж, арлыг тойрон эргүүлийн ажиллагаа явуулж буй нь “Тайваний тусгаар тогтнол” салан тусгаарлах үзлийг баримтлагч хүчнүүдэд хатуу сануулга өгч байна.

Байнгын байлдааны бэлэн байдлыг хадгална

Цэргийн арми байлдааны бэлэн байдлаа хадгалах нь аюулгүй байдлын заналхийлэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авах, үүрэг даалгавраа биелүүлэх гол баталгаа юм.

Цэргийн төв зөвлөл, цэргийн тойрогтой хамтарсан командлал нь байлдааны бэлэн байдлын зэргийн системийг хэрэгжүүлж, бэлэн байдлын хяналтыг тогтмолжуулан идэвхжүүлж хэзээ ч байлдах боломжтой байдлыг хадгалж, байлдааныг удирдах чадварыг байнга дээшлүүлж, бүх төрлийн дайралтыг зохистой, үр дүнтэй удирдан шийдвэрлэж, яаралтай аюултай үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Цэргийн төв зөвлөл 2018 онд армийн байлдааны бэлэн байдлын гэнэтийн шалгалт зохион байгуулж, 21 муж, ӨЗО, төвд шууд захирагдах хотууд болон Зүүн, Өмнөд тэнгисийн зарим хэсэгт цэрэг армийн зохион байгуулах системийг идэвхжүүлсэн. Ардын чөлөөлөх арми, зэвсэгт цагдаагийн алба байлдааны бэлэн байдлын ойлголтыг нэмэгдүүлж, бэлэн байдлын системийг чангатгаж, ээлжээр үүрэг гүйцэтгэх байдлыг эрчимжүүлж, сургуулилтыг ул суурьтай явуулж, дэг журмыг тогтоож, байлдааны бэлэн байдлын нөхцөлийг сайн хангаж, байлдааны бэлэн байдлын ээлж дараа, эргүүл хийх үүрэг хариуцлагаа үр дүнтэй гүйцэтгэв.

Бодит байлдааны шинжтэй цэргийн бэлтгэл хийх

Цэргийн хээрийн сургууль бол тайван цагийн цэрэг армид үндсэн бодит дадлага олгох үйл ажиллагаа юм. Хятадын арми цэргийн хээрийн сургуулийг гол болгож, байлдааны цорын ганц үндсэн стандартыг тогтоож, цэргийн бэлтгэлийн дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох, бэлтгэлийн ажиллагааг хянах системийг бий болгож, армийн онцгой байдалд хариу арга хэмжээ авах цэргийн бэлтгэл, хяналтыг зохион байгуулах, бэлтгэл хийж буй цэргүүдийн байлдаанд бэлэн байх хариуцлагын системийг тогтоож, олон нийтийн цэргийн сургуулилтын үйл ажиллагааг явуулж, бодит байлдааны бэлтгэлийн түвшнийг тасралтгүй дээшлүүлж байна. Зэвсэгт хүчний хэмжээнд байлдааны бодит нөхцөлд цэргийн сургалт амжилттай явагдаж байна. Хятадын цэргийн хүчин 2012 оноос хойш өөр өөр стратегийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн дивиз, бригадын түвшнээс дээш 80 гаруй хамтарсан сургуулийг хийсэн. Цэргийн тойрог болгон үндсэн үүргээ бэхжүүлэхийн тулд хамтарсан сургуулийг чанартай хийж, стратегийн чиглэлийн үүргээ хамтатгаж зүүн, өмнөд, баруун, хойд, дунд гэсэн хэсгүүдэд нэгдсэн цэргийн сургуулийг зохион байгуулж, байлдах чадвараа дээшлүүлсэн. Хуурай замын цэрэг “давшилт”, “галын хүч” гэх мэт сургуулилтыг хийсэн. Тэнгисийн цэргийн хүчин задгай далайн сургуулилтаа өргөжүүлж, нисэх онгоц тээгч баг анх удаа Номхон далайн баруун хэсэгт байлдааны сургуулилт хийсэн. Өмнөд тэнгис болон Циндаогийн ойролцоох тэнгис, агаарын орон зайд цэргийн парад болон “Хөдөлгөөнт” хээрийн сургуулийг зохион байгуулсан.

Агаарын цэргийн хүчин нь нутаг дэвсгэр даяар системчилсэн, бодит байдалд ойртуулсан сургалтыг нэмэгдүүлж, Өмнөд Хятадын тэнгист байлдааны эргүүл, Зүүн Хятадын тэнгист цагдаагийн эргүүлүүд зохион байгуулж, Номхон далайн баруун хэсэгт “Улаан сэлэм” гэх мэт цуврал системчилсэн эсэргүүцэх хээрийн сургууль зохион байгуулсан.

Пуужинт цэрэг нь шалгалтын болон хоёр талын байлдаан явуулах дадлага сургуулийг бригад, хорооны түвшинд зохион байгуулж, “Тэнгэрийн Илд” нэртэй хээрийн сургуулийг байнга зохион байгуулж байна.

Стратегийн дэмжлэгийн хүчин нь хамтарсан байлдааны системд нэгдэж, шинэ маягийн орон зайд эсэргүүцэх сургуулилт болон шуурхай хариу арга хэмжээ авах сэдвээр дадлага, сургуулийг идэвхтэй явуулсан.

Нэгдсэн хангалтын хүчин нь нэгдсэн ажиллагааны системд нэгдэж “Нэгдсэн хангалтын үүрэг-2018” хээрийн сургуулийг зохион байгуулсан.

Зэвсэгт цагдаагийн хүчин нь улс орныг хамарсан, үр дүнтэй ажиллагаа, дэлхийн хэмжээнд хариу арга хэмжээ авах, олон талт үүрэг гүйцэтгэх чадавхтай байх шаардлагын дагуу “Харуул” гэх томьёолсон нэртэй сургуулийг явуулсан.

Аюулгүй байдлын гол талбар дахь ашиг сонирхлыг хамгаалах

Цөмийн хүчин бол үндэсний бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг хамгаалах стратегийн тулгын чулуу юм. Хятадын арми цөмийн зэвсэг болон холбогдох байгууламжуудын аюулгүй байдлын удирдлагыг бэхжүүлж, бэлэн байдлын зохих

түвшинг хадгалж, стратегийн тогтоон барих чадварыг нь нэмэгдүүлж улсынхаа стратегийн аюулгүй байдлыг бататгаж, олон улсын стартегийн тогтвортой байдлыг хамгаалж байна.

Сансар огторгуй бол олон улсын стратегийн өрсөлдөөний талбар бөгөөд сансар огторгуйн аюулгүй байдал бол улсын бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийн стратегийн баталгаа юм.

Сансрын орон зайг энхийн зорилгоор ашиглах ашиг сонирхлын үүднээс Хятад улс олон улсын сансар судлалын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, холбогдох техник технологи болон хүчин чадавхын хөгжлийг түргэтгэж, сансарт суурилсан мэдээллийн нөөцийн цогц менежментийг ахиулж, сансрын нөхцөл байдлыг хянаж, сансрын аюулгүй байдлыг хамгаалж, аюулгүй нэвтэрч, сансрын хүч чадавхыг нээн ашиглах тал дээр анхааран ажиллаж байна.

Кибер орон зай бол үндэсний аюулгүй байдал болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол салбар юм. Кибер аюулгүй байдал нь дэлхийн хэмжээнд тулгамдсан асуудал хэвээр байгаа бөгөөд Хятадад ноцтой аюул заналхийлж байна. Хятадын зэвсэгт хүчин кибер орон зайн чадавхыг бэхжүүлэх ажлыг хурдасгаж, кибер аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг далайцтайгаар хөгжүүлж байна.

Терроризмыг эсэргүүцэж тогтвортой байдлыг хадгалах

Хятад улс терроризм болон экстремизмын бүхий л хэлбэрийг эрс эсэргүүцдэг. Хятадын зэвсэгт хүчин хуулийн дагуу нийгмийн дэг журмыг сахиулах, хүчирхийллийн террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж тэмцэх, улс төрийн аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалах, ард иргэдийнхээ амар амгалан аж төрөх байдлыг хамгаалах арга хэмжээнд оролцдог.

Зэвсэгт цагдаагийн хүчин нь зорилтот объектуудыг хамгаалах, газар дээр нь аюулгүй байдлыг хамгаалах, гол хэсгүүдэд хяналтын цэгийг байгуулах, хот суурин газарт зэвсэгт эргүүл хийх зэрэг үүрэг гүйцэтгэдэг. Тус байгууллага нь төрийн байгууллагуудтай хамтран хууль бус гэмт бүлэглэл болон террорист үйл ажиллагаанд цохилт өгөх, улс төрийн аюулгүй байдал, нийгмийн дэг журамд учирч болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх гэх мэт ажиллагаанд идэвхтэй оролцож “Амар тайван Хятад улс” байгуулахад гол үүрэг гүйцэтгэж байна.

2012 оноос хойш жил бүр олон тооны цэргүүдийг аюулгүй байдал, терроризмтой тэмцэх, далайн эрхийг хамгаалах, хууль сахиулах ажиллагаанд татан оролцуулсан. Их 20-ийн удирдагчдын дээд хэмжээний уулзалт, АПЕК-ийн удирдагчдын албан бус уулзалт, “Бүс,Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалт, БРИКС-ийн удирдагчдын уулзалт, ШХАБ-ын Циндаогийн дээд хэмжээний уулзалт зэрэг томоохон арга хэмжээний үеэр 10 мянга орчим аюулгүй байдлыг хамгаалах даалгаврыг гүйцэтгэж, 671 хүн барьцаалах хэрэг болон ноцтой террорист үйл явдлыг шийдвэрлэхэд оролцсон. Зэвсэгт цагдаагийн хүчин нь 2014 оноос хойш Шинжаан-Уйгурын өөртөө засах орны засгийн газарт 1588 террорист бүлэглэлийг илрүүлж, 12995 террористыг баривчлахад туслалцаа үзүүлсэн.

Ардын чөлөөлөх арми нь нийгмийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, томоохон арга хэмжээнүүдийн аюулгүй байдлыг хангахад оролцож, терроризмтэй тэмцэх, эмнэлгийн тусламж үзүүлэх, тээврийн дэмжлэг үзүүлэх зэрэг гол үүрэг гүйцэтгэдэг.

Гадаад дахь ашиг сонирхлоо хамгаалах

Гадаад дахь ашиг сонирхол бол Хятадын улсын эрх ашгийн чухал хэсэг юм.

Гадаадад байгаа хятадын иргэд, байгууллагын аюулгүй байдал хууль ёсны эрх ашгийг үр дүнтэй хамгаалах нь Хятадын цэргийн армийн хүлээх үүрэг юм.

Хятадын цэргийн арми олон улсын аюулгүй байдал, цэргийн хамтын ажиллагааг идэвхтэй дэмжиж, Хятадын гадаад дахь ашиг сонирхлыг хамгаалах системийг боловсронгуй болгож байна.

Хилийн чанад дахь үйл ажиллагаа, хамгаалалтын чадварыг сайжруулахын тулд задгай тэнгисийн цэргийн хүч болон хилийн чанад дахь ложистик байгууламжийг хөгжүүлж, цэргийн олон төрлийн даалгаврыг биелүүлэх чадварыг нэмэгдүүлж байна.

Хөлөг онгоцуудыг хамгаалах, тэнгис, далай дээрх стратегийн сувгуудын аюулгүй байдлыг хамгаалах, хилийн чанадад байгаа цагаачдыг татан авах, далайн эрхийг хамгаалах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. 2017 оны наймдугаар сард Хятадын Ардын чөлөөлөх армийн Жибути дэх туслан дэмжих бааз албан ёсоор ашиглалтад орсон. Тус бааз үйл ажиллагаагаа эхэлснээр дөрвөн удаагийн хөлгийн хамгаалалтын багийг засвар үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, 100 гаруй цэргүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хамтарсан сургуулилт зохион байгуулж, тус газрын сургуульд 600 гаруй сургалтын тоног төхөөрөмжийг бэлэглэсэн.

Йемений аюулгүй байдлын нөхцөл байдал 2015 оны гуравдугаар сард эрс муудаж, Хятадын тэнгисийн цэргийн хамгаалалтын флот Йемений Адены буланд очиж байлдааны бүсийн боомтруу шууд дайран орж байлаад 621 Хятад иргэн, Пакистан, Этиоп, Сингапур, Итали, Польш, Герман, Канад, Англи, Энэтхэг, Япон гэх мэт 15 улсын 279 иргэнийг аюулгүй нүүлгэн шилжүүлсэн.

Гамшгийн үед аврах ажиллагаанд оролцож буй байдал

Улсынхаа бүтээн байгуулалтад оролцож, ард иргэдийн амар тайван хөдөлмөр эрхлэх нөхцөлийг хангах нь Хятадын зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг мөн. “Гамшгаас аврах ажиллагаанд армийн оролцох журам”-ын дагуу Хятадын зэвсэгт хүчин барьцаанд орсон хүмүүсийг аврах, шилжүүлэх, чухал байгууламжуудын аюулгүй байдлыг хамгаалах, үнэтэд зүйлсийг тээвэрлэх, зам, гүүр, туннелийг засварлах ажилд оролцох, далайд аврах ажиллагаа явуулах, цөмийн, биологийн, химийн аюулд хяналт тавьж, өвчин эмгэгээс авран хамгаалах, гамшгийн дараах сэргээн босголтын ажилд оролцох гэх мэт үүргийг хүлээдэг. 2012 оноос хойш Ардын чөлөөлөх арми, Зэвсэгт цагдаагийн хүчин 950 мянган цэрэг, нэг сая 41 мянган цагдаа, 190 мянган автомашин болон машин механизм, 26 мянган завь, 820 нисэх онгоц (нисдэг тэрэг)-ыг гамшгийн үеийн аврах ажиллагаанд оролцуулсан. Тэд Юньнань, Лудянь мужийн

газар хөдлөлт, Хөх мөрний дунд ба доод хэсэгт болсон аадар бороо, үерийн гамшиг, Ярлунг Зангбо гол дахь хашигдсан нуурыг зайлуулах зэрэг авран туслах ажиллагаанд оролцсон бөгөөд орон нутгийн засаг захиргаанд тусалж таван сая гаруй хүнийг авран шилжүүлж, 210 гаруй өвчтөнийг тойрон эмчилж, 360 мянга гаруй тонн материалыг яаралтай тээвэрлэж, 3600 гаруй км даланг бэхэлсэн. Макаод байрласан гарнизон 2017 онд 2601 цэрэг, 160 гаруй автомашин илгээж, Хато хар салхины гамшгийн дараах аврах ажиллагааг зохион байгуулахад тус засаг захиргааны онцгой бүсийн засгийн газарт тусалсан.

ДӨРӨВ. ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙН ҮЕ ДЭХ ХЯТАДЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОЛОН ЦЭРГИЙН АРМИ

Ардын армийн хөгжлийн түүх бол өөрчлөлт шинэчлэлт, инновацийн түүх юм. Шинэ эрин үед дэлхийн цэрэг армийн өөрчлөлт шинэчлэлт, улсын аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагын улмаас Хятад улс батлан хамгаалах болон цэргийн арми орчин үеийн болгон, бүх талын цогц шинэчлэлийг хийж системийн доголдол, бүтцийн болон улс төрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хүчирхэг армийн сэргээн босголтын түүхэн алхмыг хийсэн юм.

Удирдлага, командлалын тогтолцоог шинэчлэх

Удирдлага командлалын тогтолцооны шинэчлэл нь орчин үеийн цэрэг армийн мэргэшсэн ажил үүргийн хуваарь болон мэдээллийн эрин үед тулалдах чадвар, тулалдаанд ялалт байгуулах шаардлагад нийцсэн, цэргийн армийн байлдах чадвар, бүтээлч үр ашгийг дээшлүүлэх чухал арга хэмжээ юм. “Цэргийн төв зөвлөлийн ерөнхий удирдлага, байлдааны театрын гол үүрэг гүйцэтгэгч, цэргийн ангиллын байгуулал”-ын зарчмын дагуу Цэргийн төв зөвлөлийн нэгдсэн удирдлага, стратегийн командлал, стратегийн менежментийн чадварыг бэхжүүлж, олон жилийн түүхтэй штабын систем, цэргийн том бүсийн систем, хуурай газрын цэргийн системийг халж, шинэ армийн удирдлага менежмент болон байлдааны командлалын системийг бий болгоно.

Цэргийн төв зөвлөлийн үйл ажиллагааны бүтэц, байгууллагын зохион байгуулалтыг сайжруулах үүднээс өмнөх жанжин штаб, улс төр, ар тал, хангалт, зэвсэглэл хариуцсан дөрвөн ерөнхий газрыг Нэгдсэн Штаб, Улс төрийн асуудал эрхэлсэн газар, Ар тал дэмжлэгийн газар, Зэвсэг, техникийн хөгжүүлэлтийн газар болгон өөрчилж, 11 газар шинээр байгуулсан. Ингэснээр командлах, хөгжүүлэх, удирдах, хянах тогтолцоо нь илүү оновчтой болж, шийдвэр гаргах, төлөвлөх, гүйцэтгэх, үнэлэх үүрэг хариуцлага илүү зохистой болсон.

Цэрэг болон үйлчилгээний удирдлагын систем болон манлайллыг сайжруулах.

Цэргийн арми нь:

Хуурай замын цэргийн хүчийг хөгжүүлэх үүднээс хуучин дөрвөн ерөнхий газруудыг нэгтгэн Армийн удирдах байгууллагыг байгуулсан.

Цэргийн ангилал болон цэргийн төв зөвлөлийн стратегийн тусламжийн хүчийг нэгтгэж, стратегийн дэмжлэгийн хүчинг байгуулсан.

Артиллерийн цэргийн хоёрдугаар хүчинг пуужинт цэрэг болгон шинэчлэн нэрлэсэн.

Нийтийг хамгаалах гол үүрэгтэй стратегийн байлдааны хүчийг нэгтгэж нэгдсэн үйл ажиллагааг хамгаалах корпусыг байгуулж, “цэргийн төв зөвлөл -цэргийн ангилал-цэргийн арми”-ийг нийлүүлж удирдлагын тогтолцоог бий болгосон.




图 1 军队领导管理体系架构图

Хамтарсан үйл ажиллагааны командлалын системийг бий болгож сайжруулах

Цэргийн төв зөвлөлийн хамтарсан үйл ажиллагааны командын байгууллагыг сайжруулж цэргийн тойргуудыг байгуулснаар энх тайван болон дайны аль ч үед байнгын, мэргэшсэн, удирдлагын системтэй болсон. Шэньян, Бээжин, Ланжоу, Жинан, Нанжин, Гуанжоу, Чэнду зэрэгт байрлах долоон цэргийн тойргоо зүүн, өмнөд, баруун, умард, төв гэсэн таван тойрог болгосон. Шинэчлэлээр “Цэргийн төв зөвлөл -байлдааны командлал-цэргийн хүчин” гэсэн байлдааны командлалын тогтолцоог бий болгов.




图 2 军队作战指挥体系架构图

Хууль эрх зүйн хяналтын тогтолцоог бий болгох

Хятадын цэргийн арми цэргийн төв зөвлөлийн сахилга батыг шалгах хороог шинээр байгуулсан.

Хятадын цэргийн төв зөвлөлийн шууд удирдлага цэргийн төв зөвлөлийн салбар болон театруудад сахилга батыг шалгах хороог байгуулж, цэргийн зөвлөлийн улс төр, хуулийн хороог шинээр байгуулж бүс бүрд цэргийн шүүх, цэргийн прокурор, цэргийн зөвлөлийн аудитын газрыг байгуулж, аудитын тогтолцоонд өөрчлөлт хийж, суурин аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрх мэдэл, гүйцэтгэх эрх, хяналтын эрх мэдэл бүхий харилцан уялдсан тогтолцоог хэрэгжүүлсэн.

Хэмжээ бүтэц болон хүчний бүрэлдэхүүнийг сайжруулах

Хэмжээ бүтэц, хүчний бүрэлдэхүүнийг сайжруулах нь Хятадын армийн байгууллагын хэлбэрийг орчин үежүүлж, Хятадын онцлогтой орчин үеийн цэргийн хүчний системийг бий болгох гол алхам юм. Бүтцийг сайжруулах, шинэ хүчийг хөгжүүлэх, харилцааг зохицуулах, тооны хэмжээг багасгах шаардлагын дагуу тоон хэмжээний хэлбэрээс чанар, үр ашигт шилжүүлж, хүн хүчний нягтарлаас шинжлэх ухаан технологийн хэлбэрт өөрчлөхийг зорьж байна.

Армийн цар хүрээг тохируулж, хүчний бүтцийн зохион байгуулалтыг өөрчлөх

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний тоог 300 мянгаар цөөрүүлж, хоёр саяд хүргэсэн.

ХАЧА нь тоо хэмжээ масштабын загвараас чанар, үр ашигт шилжиж боловсон хүчнээ цомхотгохыг эрмэлзэж байна. Офицер болон энгийн алба хаагчдын хуваарилалтын цар хүрээг өргөжүүлж, бүх шатны байгууллагуудын зохион байгуулалтыг нь цомхон болгож, удирдлагын түвшний хүмүүс, соёл урлаг, спорт, хэвлэл, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, агуулах, эрдэм шинжилгээний хүрээлэн гэх мэт байгууллагын хорооноос дээш нэгжийн бие бүрэлдэхүүнийг 25 орчим хувиар, байлдааны бус нэгжийн алба хаагчдын тоог бараг 50 хувиар бууруулсан.

Хуурай замын цэргийн алба хаагчдын тоо хэмжээг их хэмжээгээр бууруулж, агаарын цэргийн тоо хэмжээг тогтвортой байлгаж, тэнгисийн болон пуужинт цэргийн тоог зохих хэмжээгээр нэмэгдүүлж, цэргийн болон нөөц хүчний бүтцийг оновчтой болгосон.

Байлдааны анги, нэгтгэлүүдийн бүтэц, зохион байгуулалтад хийгдсэн шинэчлэлээр шинэ хэлбэрийн байлдааны хүчнийг эмхлэн байгуулсан.

Хуурай замын цэргийн 18 армийг нэгтгэж 13 болгосон. Зэвсэгт хүчний үндсэн байлдааны анги, нэгтгэлүүдэд “Арми-бригад-батальон” тогтолцоог хэрэгжүүлж, төрөл, мэргэжлийн цэргийн байлдааны чадавхыг бэхжүүлж, удирдлагын шатлалыг бууруулсан. Тусгай ажиллагааны, стерео хэлбэрийн давшилт хориглолт хийх, газар уснаа байлдаан явуулах, алслагдсан далайн бүсэд хориглолт зохион байгуулах, стратегийн тээвэрлэлт хийх зэрэг шинэ хэлбэрийн байлдааны хүчнийг нэмэгдүүлж, анги, нэгтгэлийн бүтэц зохион байгуулалтыг холимог, олон талт үүрэг гүйцэтгэх, уян

хатан зэрэг чиглэлд хөгжүүлж байна.

Цэргийн академи, шинжлэх ухаан, судалгааны тогтолцоог тэнцвэртэй хөгжүүлж, боловсронгуй болгох

Ардын чөлөөлөх арми, Зэвсэгт цагдаагийн хүчин өмнө нь байсан 77 их, дээд сургуулийг 44 болгож нэгтгэсэн бөгөөд шинээр батлан хамгаалах их сургууль болон Батлан хамгаалах шинжлэх ухаан, технологийн их сургуулийг дахин байгуулсан.

Цэргийн төв зөвлөлийн Цэргийн шинжлэх ухаан технологийн хороог байгуулж, шинээр байгуулж байгаа цэргийн шинжлэх ухааны дээд сургууль, цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнг эмхлэн байгуулж, цэргийн шинжлэх ухааны байгууллагуудыг түшиглэн их, дээд сургуулиудын хүчин чадлыг цэргийн шинжлэх ухаанч хүчээр бэхжүүлсэн.

Цэргийн бодлогын системийг шинэчлэх

Хятад Улсын Зэвсэгт хүчин нь байлдааны хүчний стандарт, үр ашгийг цэргийн бодлогын тогтолцоог шинэчлэх шалгуур болгож, цэргийн албан хаагчдын идэвх, санаачилгатай байдал, бүтээлч байдлыг идэвхжүүлж, цэргийн бодлогын шинэчлэлийг цогцоор нь боловсруулж Хятадын онцлогтой социалист нийгмийн цэргийн бодлогын тогтолцоог бий болгоно.

Арми дахь намын байгуулалтын тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлж, Намын төв хорооны эрх мэдэл, төвлөрсөн удирдлагыг хамгаалж, намын цэрэг армийг удирдах онцгой эрхийг баталгаажуулна. Цэрэг арми намын улс төр, үзэл суртал, зохион байгуулалт, ажлын хэв маяг, сахилга батын тогтолцоог сайжруулах үүднээс “Шинэ эриний арми дахь намын тогтолцоог бэхжүүлэх шийдвэр” гэх мэт хууль тогтоомжийг боловсруулсан.

Шинэ эрин үед цэрэг армийн үүргээ бүрэн хэрэгжүүлж, үр дүнтэй хамгаалахын тулд цэргийн хүчийг ашиглах бодлогын тогтолцоог шинэчилж “Далайн хөлөг онгоцыг хамгаалах үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, цэргийн стратегийн удирдлагын тогтолцоо, байлдааны бэлэн байдлын журам, хамтарсан байлдаан хийх журам зэргийг боловсронгуй болгосон.

“Батлан хамгаалах тээврийн тухай хууль”, “Цэргийн байгууламжийг хамгаалах хууль”, “Иргэний албатын журам” гэх мэт хууль тогтоомжийг дахин засварлаж, цэргийн бэлтгэлийн журам, цэргийн бэлтгэлийн хөтөлбөрийг сурталчлан хэрэгжүүлсэн.

Офицеруудыг мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, цэргийн албан хаагчдын хангамжийг сайжруулах, цэргийн албан хаагчийн хүндэтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн сургуулилт, техник хэрэгсэл, тоноглолыг хөгжүүлж, ложистикийн барилга байгууламж, цэргийн шинжлэх ухааны судалгаа, үндэсний батлан хамгаалах дайчилгаа гэх мэтийн бодлогын тогтолцоог боловсронгуй болгож, цэргийн офицерын хууль, цэргийн албаны хууль гэх мэт хуулиудыг тогтоох үйл явцыг урагшлуулсан.

Цэргийн удирдлагын бодлогын тогтолцоог шинэчилж, цэргийн тогтолцооны үйл

ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, цэрэг армийн хөгжлийг дэмжсэн.

“Дотоод журам”, “Сахилга батын журам”, “Жагсаалын журам”, “Цэргийн хууль тогтоомжийн ажлын журам” гэх мэт хуулийн дүрэм журамд засвар хийж, стратегийн удирдлага, цэргийн зардлын удирдлага, цэргийн эрх зүйн тогтолцоог шинэчилсэн.

Цэргийн төлбөрт үйлчилгээг бүрэн зогсоосон. 2018 оны зургаадугаар сар хүртэл цэргийн бүх түвшний байгууллага, цэргийн арми тэдгээрийн харьяа байгууллагын үл хөдлөх хөрөнгийн түрээс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүлээн авалт гэх мэт 15 салбарын төлбөрт үйлчилгээнүүд үндсэндээ зогссон бөгөөд бусад 100 мянга гаруй төлбөрт үйлчилгээний төслүүдийг хуваарийн дагуу түдгэлзүүлсэн байна.

Шинэчлэлийн дараах цэргийн хүчний төрөл болон зэвсэгт цагдаагийн хүчин

Хуурай замын цэргийн хүчин улсынхаа бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгийг хамгаалахад орлуулшгүй үүрэг гүйцэтгэдэг. Хуурай замын цэргийн хүчинд байлдааны ажиллагаанд бэлэн байх арми (маневрлах, оперативный), хилийн болон эргийн хамгаалалтын арми, цагдаагийн хамгаалалтын болон бэлэн байдлын арми, Шинжаан, Төвдийн гэх мэт таван бүсийн хүчнүүд багтдаг.

Зүүн бүсэд 71, 72, 73, Өмнөд бүсэд 74, 75, Баруун бүсэд 76, 77, Хойд бүсэд 78, 79, 80, Төвийн бүсэд 81, 82, 83 дугаар арми тус тус хамаардаг. Хориглох байлдаан явуулах, олон хэмжээст давших стратегийн шаардлагад нийцүүлэн бүсэд бэхэлсэн хамгаалалтаас бүх бүсийн хөдөлгөөнт хамгаалалтад шилжих явцыг хурдасгаж, нарийвчилсан, олон хэмжээст, тасралтгүй ажиллагааны чадавхыг сайжруулж, хүчирхэг орчин үеийн хуурай замын арми байгуулахыг хичээж байна.

Тэнгисийн цэргийн хүчин нь үндэсний аюулгүй байдал болон хөгжлийн ерөнхий байдалд маш чухал байр суурь эзэлдэг. Тэнгисийн цэргийн хүчин нь шумбагч завины, байлдааны хөлөг онгоцны, авиацын, тэнгисийн явган цэргийн, эргийн хамгаалалтын алба зэргээс бүрддэг. Зүүн, Өмнөд, Хойд Хятадын тэнгисийн бүс, тэнгисийн явган цэргийн корпус гэх бүст хуваагддаг. Флот нь суурин газар (бааз), шумбагч онгоц, гадаргын байлдааны хөлөг онгоц, нисэхийн бригад гэх мэтэд харьяалагддаг.

Тэнгисийн цэргийн хүчин зэргэлдээ далай тэнгисийн хамгаалалтаас гадаад далайн хамгаалалтын стратегид шилжих ажлын хэрэгжилтийг түргэсгэж, улмаар стратегийн хориглолт ба сөрөг довтолгоо, далай тэнгисийн маневр ажиллагаа, далай тэнгис дэх цэргүүдийн хамтарсан ажиллагаа, цогц хамгаалалт, нэгдсэн дэмжлэг зэрэг чиглэлээр хүчин чадавхаа сайжруулж хүчирхэг, орчин үеийн тэнгисийн цэргийн хүчин цогцлоохыг эрмэлзэж байна.

Агаарын цэргийн хүчинд таван тойрог дахь агаарын цэргийн командлалууд, агаарын десантын корпус багтдаг. Тойргийн командлалууд дахь нисэх хүчний удирдлаган дор агаарын цэргийн бааз, агаарын десант, агаарын довтолгооноос хамгаалах, газар-агаар ангиллын пуужингийн бригад болон радиолокацын бригадууд багтдаг.

Агаарын цэрэг нь улс орны агаарын орон зайг хамгаалах хэлбэрээс давшилт, хориглолтыг хослуулах хэлбэрээр хөгжиж, мэдээллийн дайны шаардлагад нийцсэн

агаар-сансрын довтолгооноос хамгаалах хүчний тогтолцоог бүрдүүлж, энэ хүрээнд стратегийн урьдчилан мэдээлэх, агаарт цохилт өгөх, довтолгооноос хамгаалах, мэдээллийн саатуулга хийх десантаар бууж байлдах, стратегийн хүчнийг шилжүүлэн байрлуулах, нэгдсэн хангалт хийх чадвартай болж байна.

Пуужинт цэргийн хүчин нь улсынхаа бүрэн эрхт, аюулгүй байдлыг хамгаалахад гол чухал үүрэг гүйцэтгэдэг. Пуужинт цэргийн хүчинд цөмийн, ердийн, хамгаалах хүчин гэх мэт багтдаг.

Пуужинт цөмийн цэрэг нь мэдээлэлжүүлэх байгуулалтыг эрчимжүүлж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан, зэвсэглэл техникийн инновацийг хөгжүүлж, пуужингийн аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг дээшлүүлж, ердийн болон цөмийн хүчний хосолсон тогтолцоог сайжруулж, стратегийн сүрдүүлэг үзүүлэх, богино хугацаанд дунд болон алсын зайнд оновчтой цохилт өгөх боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Стратегийн дэмжлэгийн хүчин бол үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шинэ хэлбэрийн хүч бөгөөд байлдааны чадварыг нэмэгдүүлэх гол чухал хүч юм. Стратегийн дэмжлэгийн хүчин нь байлдааны ажиллагааны газар орон, мэдээлэл, холбоо, мэдээллийн аюулгүй байдал, шинэ технологийн туршилт зэрэгт дэмжлэг үзүүлэх зэргээс бүрддэг.

Системийн интеграцчилал, цэрэг иргэний нэгдсэн стратегийн шаардлагын дагуу байлдааны шинэ хэлбэрийн хүчнүүдийн хөгжлийг түргэтгэж, орчин үеийн стратегийн дэмжлэг үзүүлэх хүчнийг бий болгохыг эрмэлзэнэ.

Нэгдсэн хангалтын хүчин нь нэгдсэн хангалтыг зохион байгуулах, стратегийн ажиллагааны үед дэмжлэг үзүүлэх гол хүч бөгөөд Хятадын онцлогтой орчин үеийн цэргийн хүчний тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Нэгдсэн хангалтын хүчин нь хадгалалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, тээвэрлэлт, газрын тос дамжуулах хоолой, барилга байгууламжийн удирдлага, нөөцийн хөрөнгийн менежмент, худалдан авалт гэх мэт ажиллагааг хамардаг бөгөөд Үши, Гүйлин, Синин, Шэнян, Жэнжоу гэх таван газарт тус төв нь мөн Хятадын чөлөөлөх армийн төв эмнэлэг, урьдчилан хянах төв зэрэг нь байрладаг. Хамтарсан үйл ажиллагаа, сургалт, хамгаалалтын шаардлагын дагуу хамтарсан үйл ажиллагааны тогтолцоог хурдасгаж, хамтын хамгаалалтын чадварыг сайжруулж, орчин үеийн хүчирхэг логистикийн хангалтын хүчийг бий болгохыг зорьж байна.

Зэвсэгт цагдаагийн хүчин нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалж, ард иргэдийн сайн сайхан амьдралыг хамгаалах чиглэлээр томоохон үүрэг хариуцлагыг хүлээдэг. “Цэргийн төв комисс-Зэвсэгт цагдаагийн хүчин-отряд” гэсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг. Олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хүчин, улсын далайн удирдах газар харьяалагддаг байсан далайн хамгаалалтын албыг зэвсэгт цагдаагийн албанд шилжүүлсэн. Зэвсэгт цагдаагийн алба алтны уурхай, ой, усан цахилгаан станцын бүрэлдэхүүнийг нийтэд нь холбогдох чиг үүргийн байгууллагуудад нь шилжүүлж цэргийн бус мэргэжлийн баг болгон өөрчлөн зохион байгуулсан. Мөн зэвсэгт цагдаагийн хүчин гаалийн харуулын цэргүүдийг татан авч ингэснээс удирдлага зохион байгуулалт, ажил эрхлэлт илүү уялдаа

холбоотой болсон. Зохион байгуулалт хийсний дараа зэвсэгт цагдаагийн хүчин нь дотоодын харуул хамгаалалт, хөдөлгөөнт, тэнгисийн цагдаагийн хүчийг өөртөө нэгтгэсэн. Олон үүрэг гүйцэтгэх стратегийн шаардлага болон нийгмийн тогтвортой байдлыг бүрдүүлэх үүднээс зэвсэгт цагдаагийн хүчин нь хамгаалалт, онцгой байдал, терроризмтэй тэмцэх, далайн эрхийг хамгаалах, захиргаааны шийдвэрийг албадан хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж орчин үеийн хүчирхэг зэвсэгт цагдаагийн хүчнийг бий болгохыг эрмэлзэж байна.

Батлан хамгаалах болон зэвсэгт хүчний бүтээн байгуулалтыг бүх талаар нь ахиулах

Үзэл бодол, улс төрийн байгуулалтыг цэрэг армийн төрөл бүрийн бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд тавьдаг. Си Зиньпиний армийг бэхжүүлэх үзэл санааны удирдах байр суурийг тууштай баримталж, Си Зиньпин Ерөнхий нарийн бичгийн дарга болон Намын төв хорооны үндсэн байр суурийг тууштай баримталж, Намын төв хорооны эрх мэдэл, төвлөрсөн удирдлагыг тууштай хамгаалж, Цэргийн төв зөвлөлийн удирдлагын хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлснээр улс төрийн мэдлэг, ерөнхий ойлголт, үндсэн ойлголт, даган дуурайх ойлголт улам бүр нэмэгдэх болно. «Шинэ нөхцөл байдал дахь цэрэг армийн улс төрийн зарим асуудлын талаарх шийдвэр» 2014 оны 12 дугаар сард гарч улс төрийн сургалтыг ахиулсан. Цэргийн төв зөвлөлийн намын хурал 2018 оны наймдугаар сард болж шинэ эрин үеийн цэргийн удирдлага болон цэргийн намын бүтээн байгуулалтын ажлыг цогцоор нь бэхжүүлэв. Оюунлаг, эрдэм мэдлэгтэй, зориг хатуужилтай, ёс суртахуунтай шинэ үеийн хувьсгалт цэргүүдийг итгэл үнэмшлээр төлөвшүүлж, төмөр шиг хатуу итгэл үнэмшилтэй, хариуцлагатай, үүрэг даах чадвартай болгон төлөвшүүлэхийг зорьж байна.

Батлан хамгаалах салбар дахь техникийн шинэчлэл болон цэргийн номлолыг бэхжүүлэх

Шинжлэх ухаан, технологийг ашигласан шинэлэг цэргийн стратегийг явуулахын тулд Хятадын зэвсэгт хүчин удирдаж буй газруудынхаа техник технологийн хүчин чадлыг бэхжүүлж, инновацийг эрчимжүүлэхийг зорьж байгаа бөгөөд бие даасан инновацийн чиглэлд томоохон амжилт гаргасны нэг жишээ нь ТИАНХӨ-2 супер компьютерийг үйлдвэрлэсэн явдал юм. Цэргийн онол дахь инновацийг сурталчлахын тулд дайн, байлдааны асуудалд анхаарлаа төвлөрүүлж, үндэсний батлан хамгаалах, арми байгуулахад онолын дэмжлэг үзүүлэх зорилгоор стратеги, хамтарсан үйл ажиллагаа, мэдээлэлжүүлэлтийн бүтээн байгуулалт зэрэг онолын цуврал үр дүнг санаачлан эхлүүлсэн. Дайн байлдаанд анхаарлаа төвлөрүүлснээр Хятадын зэвсэгт хүчин цэргийн сургаалд шинэлэг зүйл хийж, цэргийн стратеги, хамтарсан үйл ажиллагаа, мэдээлэлжүүлэлтэд үр дүнгээ өгч, батлан хамгаалах, цэргийн хөгжилд онолын дэмжлэг үзүүлсэн юм.

Орчин үеийн зэвсэг тоноглолын системийг бий болгох

Дэвшилтэт зэвсэг тоноглолын системийн бүтцийг сайжруулахын тулд арми тус бүрийн зэвсэг, тоноглолын хөгжлийг цогцоор нь сайжруулж, байлдааны

тоног төхөөрөмж, мэдээллийн систем, хамгаалах тоног төхөөрөмжийг цогцоор нь хөгжүүлж, стандарт, цуврал, бүх нийтээр хэрэглэх түвшинд хүргэх хэрэгтэй. Хуучин тоноглолуудыг их хэмжээгээр шигшиж, шинэ дэвшилтэт технологиор тоноглогдсон байдлыг бий болгоно. 15 төрлийн танк, 052D загварын сөнөөгч хөлөг, J 20 загварын байлдааны нисэх онгоц, Дунфөн-26 дунд болон холын зайн баллистик пуужин болон бусад хэрэгслийг армиудад байрлуулсан.

Дайн хийхэд зориулсан орчин үеийн ложистикийг байгуулах

Нэгдсэн ложистикийг гол болгосон, цэргийн төрлийг нөхвөр болгосон, бүрэн гүйцэд, хоёр шугамыг холбосон хамгаалалтын тогтолцоог байгуулж, стратегийн дайны хүчийг гол болгосон нийгмийн хамгааллыг түшиглэсэн, нэгдсэн, цомхон, үр ашигтай ложистикийн хүчний тогтолцоог бий болгож, ложистикийн хүчийг дайны бүсийн нэгдсэн, бүс дамнасан, Хятад болон гадаадын хамтарсан, өмнө болон хойд талын хамтарсан сургуулилтуудад ашиглаж түргэн дэмжин хүрээлэх, бүрэн хэмжээгээр оролцох, нарийн чанд баглан хамгаалах чадваруудыг бий болгоно.

Стратегийн удирдлагыг бэхжүүлэх

Эрэлтэд тулгуурласан, нөөц хувиарлалтын төлөвлөгөөг баримталж «эрэлт-төлөвлөгөө-урьдчилсан тооцоо-хэрэгжүүлэлт-үнэлгээ өгөх» гэсэн стратегийн удирдлагын дарааллыг баримтална. Армийн хөгжлийн стратеги болон гол хүрээ, армийн төрөл, зэвсэгт цагдаагийн армийн хөгжлийн стратегийг тодорхойлж, стратегийн төлөвлөгөө болон төлөвлөгөөний системийг бий болгоно. Армийн стратегийн төлөвлөгөөний ажлуудыг стандартжуулж, “Цэргийн байгууламжийн хөгжлийн XIII таван жилийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж бүхэлд нь үнэлэн дүгнэж, хянаж, тохируулах гэх мэт тогтолцооны системийг хэрэгжүүлнэ.

Цэргийн дэглэмийг хатуу сахилга баттай, хуулийн дагуу удирдах

Хятадын онцлогтой цэргийн эрх зүйт тогтолцоог сайжруулж цэргийн удирдлагын хэлбэрийн үндсэн өөрчлөлтийг ахиулна. Цэргийн бэлтгэл ажилд тавих хяналтыг бэхжүүлж, энх тайван үед бий болсон хор хөнөөлтэй зүйлийг засан тохинуулна. Хуулийг сурталчлан таниулах сургалтуудыг ихээр явуулж, хууль зүйн зөвөлгөө өгөх үйлчилгээг бий болгож, эрх зүйт цэргийн хуаранг бий болгохыг эрчимжүүлнэ.

Армийн удирдлагыг чандлан бэхжүүлж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, цэргийн командлалын тогтолцоог сэргээн сайжруулж, армийн аюулгүй байдлын томоохон шалгалтыг зохион байгуулж, аюулгүй байдлын томоохон аюул заналхийллийг шалгах тогтолцоог чангатгаж, хэв журам сахиулах ажлын хүчийг нэмэгдүүлж, цэргийн тээврийн хэрэгслийн удирдах тусгай журам гаргах, сахин хамгаалах ажлыг тогтсон хугацаанд мэдэгдэж байх тогтолцоог бий болгож цэрэг армийн сайн сайхан байдлыг хамгаална.

Намын үзэл суртлыг дэлгэрүүлж, шударга төрийг байгуулж авлигатай тэмцэх тэмцлийг урагшлуулна

Улс төрийн сахилга бат, ёс журмыг хатуу сахиж Гуо Босион, Сюй Цайхоу, Фан

Фэнхуй, Жан Ян гэх мэт хүмүүсийн сахилга бат, хууль зөрчсөн хэргүүдийг хатуу шалгаж шийдвэрлэсэн.

Сахилга бат, хууль тогтоомжийн дагуу авлигачдыг хатуу чанга шийтгэж томоохон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд бараа худалдах гэх мэт салбарт тусгай хяналт зохицуулалт хийнэ.

Анхан шатны нэгжид хяналт шалгалтын тогтолцоог бий болгож офицер, цэргүүдийн эргэн тойронд буй бичил авлига болон шударга бус үйлдлийг засаж залруулна.

Улс төрийн хяналт шалгалтыг гүнзгийрүүлж, цэргийн зөвлөлийн агентлагууд болон томоохон газрууд дахь хяналт шалгалт болон буцаж очиж шалгах, тойрон шалгах ажиллагааг дуусгана. Гол гол салбар, томоохон төсөл, чухал сан хөмрөгт хийх аудитын шалгалт нэмэгдүүлж, боловсон хүчний эдийн засгийн хариуцлагын хяналтыг чангатгаж, орлого зарлагын аудит, үйл ажиллагааны мөрөөр хийх аудитыг идэвхтэй явуулна.

2012 оноос хойш 39 мянган нэгж, 13 мянган нэгдлээс дээших удирдагчдыг шалгасан. Авлигын эсрэг тэмцэл ялалт байгуулж, улс төрийн чигч шударга улс төрийн хэв маяг үндсэндээ бүрдсэн.

Батлан хамгаалах дайчилгааны хүчний шинэчлэлийг урагшлуулж байна

Батлан хамгаалах дайчилгааны байгууллагын удирдлагын тогтолцоог зохицуулж, нөөц хүчний бүтээн байгуулалтыг бэхжүүлж, орон нутгийн цэргийн тулгуур бүрэлдэхүүний тоо хэмжээг цомхотгож, урьдчилан бэлтгэл цэргийн албаны цар хүрээ, бүтэц, хүчний бүрэлдэхүүний шинэчлэлийг гүнзгийрүүлж, бэлтгэл болон идэвхтэй цэргийн армийн нэгдмэл байгууламж болон ашиглалтыг урагшлуулж, хамгаалалтын хуурай газрын цэргийн армийг хамгаалалтын олон цэргийн армийн төрөл болгон өөрчлөх өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Нам болон улсын байгууллагуудын өөрчлөлтийг эрчимжүүлж, цэргийн албанаас тэтгэвэртээ гарсан хүмүүсийн хэргийг хамаарах газар байгуулж муж, хот, хошуу, суурин, тосгонд тэтгэвэрт гарсан цэргийн албан хаагчдын үйлчилгээний баталгааны тогтолцоог ахиулж, хэд хэдэн халамж, хөнгөлөлтийн арга хэмжээг бий болгосон.

Цэргээ хайрлаж гэр бүлийг нь халамжлах, засгаа дэмжиж иргэнээ хайрлах үзлийг лавшруулж ядууралтай тэмцэх ажил идэвхтэй оролцож, цэргийнхэн, засгийн газар, цэрэг, энгийн иргэдийн эв нэгдлийг бэхжүүлж, цэргийн албан хаагчдыг хүндэтгэдэг, тэдэнд давуу эрх олгосон нийгмийн уур амьсгал одоо бүрэлдэж байна.

ТАВ. ЗҮЙ ЗОХИСТОЙ БАТЛАН ХАМГААЛАХ ЗАРДАЛ

Хятад улс хөгжил болон аюулгүй байдлыг уялдуулж, баян улс, хүчирхэг улсыг нэгтгэж, батлан хамгаалах болон эдийн засгийг зохицуулан хөгжүүлж, хэмнэлттэй цэргийн бүтээн байгуулалтын зарчмыг баримталж улсынхаа эдийн засгийн хөгжлийн түвшин болон батлан хамгаалах шаарлагыг үндэслэн батлан хамгаалах зардлынхаа хэр хэмжээг зохистой тодорхойлж хууль тогтоомжийн дагуу батлан хамгаалах зардлаа удирдан, зарцуулж байна.

Өөрчлөлт шинэчлэлийн үеэс Хятадын батлан хамгаалах зардал тогтвортой байдлаас зохистойгоор өсөх хандлагатай байсан бөгөөд улсын эдийн засаг болон санхүүгийн зардалтай харгалзан зохистойгоор өсч байна. ДНБ-нд эзлэх батлан хамгаалах зардал нь 1979 оны хамгийн өндөр хувь болох 5.43 хувиас буурсаар 2017 онд 1.26 хувь болсон бөгөөд ойрын гучин жилд 2 хувь дотор байна. 1979 онд улсын батлан хамгаалах салбарын зардал улсын төсвийн зардлын 17.37 хувийг эзэлж байсан бол 2017 онд 5.14 хувь болж 12 хувиар буурч ерөнхийдөө буурсан гэдэг нь тодорхой байна.

2012 оноос хойших Хятадын батлан хамгаалах зардал

Шинэ эрин үед орсноор улсынхаа шинэчлэлийн үйл явцтай уялдуулан, Хятадын олон улсын байр суурьтай зохицуулан, улсын аюулгүй байдал болон хөгжлийн ашиг сонирхолтой нийцсэн хүчирхэг цэрэг армитай болох, дэлхийн дэвшилтэт цэрэг армийн түвшнээс хоцрогдсон байдлыг багасгах, орчин үеийн дайн байлдаан явуулах чадвар дутмаг байдлыг шийдвэрлэхийн тулд Хятадын батлан хамгаалах зардлын хэмжээ тогтвортой өсч зардлын бүтцийг оновчтой болгосоор байна.

Хятадын батлан хамгаалах зардлыг зориулалтын дагуу хувиарладаг бөгөөд голчлон хүмүүсийн амьжиргааны зардал, сургалтын зардал, тоног төрөөрөмжийн зардалд зарцуулдаг.

Хүмүүсийн амьжиргааны зардалд цэргүүд, иргэний албан хаагчид, цэргүүд,

хөлсний албан бус хүмүүс болон тэтгэвэрт гарсан хүмүүсийн цалин, нөхөн олговор, хоол унд, иж бүрэн хувцас, даатгал, нийгмийн хангамж, тэтгэмж зэрэг багтдаг.

Сургалтын зардлыг армийн бэлтгэл, академийн боловсрол, инженерийн байгууламж барих, хамгаалах гэх мэт өдөр дутмын бусад зардалд ашигладаг.

Тоног төхөөрөмжийн зардалд зэвсэг, техник хэрэгслийн судалгаа, туршилт, худалдан авах, засвар үйлчилгээ, тээвэрлэлт, хадгалалт гэх зэрэг ордог.

Батлан хамгаалах зардлын хамгааллын хүрээнд үүргээ гүйцэтгэж байгаа арми, бэлтгэл анги, ардын цэрэг ордог.

Батлан хамгаалахын нэмэгдсэн зардлыг 2012 оноос дараах зүйлсэд голчлон ашиглаж байна.

1. Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд дасан зохицох цэргүүдийн нийгмийн халамжийг сайжруулах, цалинг тогтмол нэмэгдүүлэх механизмыг тогтоох, анхан шатны цэргүүдийн ажил, сургалт, амьдралын баталгааны нөхцөлийг байнга сайжруулах;

2. Зэр зэвсэг, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хуучирсан тоног төхөөрөмжийг устгаж заримыг нь засч шинэчлэх, нисэх онгоц зөөгч, байлдааны онгоц, пуужин, танк зэрэг шинэ зэвсэг, техникийг худалдан авах, зэвсэг техникээ шинэчлэх;

3. Батлан хамгаалах болон армийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, армийн удирдлагын тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн, цэргийн бодлого гэх мэтийг шинэчлэх

4. Бодит байлдааны бэлтгэлийг баталгаажуулах, стратегийн бэлтгэл, цэргийн бусүүдийн хамтарсан бэлтгэл, зэвсгийн бэлтгэл гэх мэт бэлтгэлийн баталгааг хангаж, загварчилсан, сүлжээтэй, сөргөлдсөн бэлтгэлийн нөхцөлийг хангах;

5. Олон улсын энхийг сахиулах ажиллагаа, усан онгоцноос хамгаалах, хүмүүнлэгийн аврах ажиллагаа, яаралтай аврах ажиллагаа, гамшгаас аврах ажиллагаа гэх мэт олон төрлийн цэргийн үүрэг даалгаврыг биелүүлэхэд;

Хятад улсын батлан хамгаалах салбарын зардал 2012-2017 онд 669.192 тэрбум юаниас 1043.237 тэрбум юань болж нэмэгджээ. Хятадын ДНБ тухайн жилийн үнээр тооцвол 9.04 хувь, төсвийн зарлага 10.43, батлан хамгаалах зардал 9.42 хувиар тус тус өссөн байна. Батлан хамгаалах зардал нь тус улсын ДНБ-ий 1.28 хувийг эзэлдэг бөгөөд төсвийн зарлагын 5.26 хувийг эзэлж байна.

Хятадын батлан хамгаалах зардалд төсвийн зардал болон төсвийн менежментийн хатуу тогтолцоог хэрэгжүүлдэг.

Батлан хамгаалах зардлын олон улсын харьцуулалт

Батлан хамгаалахын зардлаараа дэлхийд тэргүүлдэг улсуудтай харьцуулахад Хятадын батлан хамгаалахын зардал нь 2017 онд ДНБ ба улсын төсвийн зардалд эзлэх хувь мөн улсын ард иргэд болон цэргийн албан хаагчдын нэг хүнд ногдох хэмжээгээр харьцангуй бага түвшинд байна.

Хятад улс дэлхийн хоёр дахь том эдийн засагтай улс болсон. Батлан хамгаалах зардлын хэмжээгээрээ дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгдэж буй нь Хятадын батлан хамгаалахын хэрэгцээ, эдийн засгийн хэмжээ, хамгаалах шинжтэй батлан хамгаалахын бодлоготой уялдаж буй юм. Хятадын батлан хамгаалах салбарын зардлын хэмжээ 2017 онд АНУ-ын батлан хамгаалах зардлын дөрөвний нэгд хүрэхгүй байсан.

Хятадын батлан хамгаалах зардлын ДНБ-ийг эзлэх дундаж хэмжээ 2012-2017 онд 1.3, АНУ 3.5, ОХУ 4.4, Энэтхэг 2.5, Их Британи 2, Франц 2,3, Япон 1, Герман 1,2 орчим тус тус хувьтай байсан. Хятадын батлан хамгаалах зардлын ДНБ-д эзлэх дундаж хэмжээ дэлхийн хамгийн өндөр батлан хамгаалах зардалтай орнуудаас зургаадугаарт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн таван орны хамгийн багад тооцогдож байна. Төсвийн зарлага дахь батлан хамгаалах салбарын зардлын эзлэх хувь талаас нь авч үзвэл 2012-2017 онд Хятад дахь батлан хамгаалах зардлын дундаж хувь ойролцоогоор 5.3, АНУ ойролцоогоор 9.8, ОХУ ойролцоогоор 12.4, Энэтхэг ойролцоогоор 9.1, Англи ойролцоогоор 4.8, Франц ойролцоогоор 4.0, Япон ойролцоогоор 2.5, Герман ойролцоогоор 2.8 хувь тус тус байсан. Төсвийн зарлага дахь батлан хамгаалах зардлын дундаж хувиараа Хятад улс дөрөвдүгээрт жагсаж байна.

Нэг хүнд ногдох батлан хамгаалах зардлын хувьд авч үзвэл 2017 онд Хятад иргэдийн нэг хүнд ногдох батлан хамгаалах зардал 750 юань байсан бол АНУ-ын 5, ОХУ-ын 25, Энэтхэгийн 231, Их Британийн 13, Францын 16, Японы 29. Герман, 20 хувь байв. Хятадын нэг цэрэгт ногдох батлан хамгаалах зардал 521,600 юань байгаа нь АНУ-ын 15, ОХУ-ын 119, Энэтхэгийн 166, Их Британийн 27, Францын 38, Японы 35, Германы 30 хувьтай тус тус тэнцэж байна. Хятад иргэдийн нэг хүнд ногдох батлан хамгаалах зардлын хэмжээгээрээ долдугаарт, цэргийн албан хаагчдын нэг хүнд ногдох батлан хамгаалах зардлын хэмжээгээр зургаадугаарт жагсч байсан.

Хятад улс байнга батлан хамгаалах зардлын тайлангаа хэвлэн нийтэлдэг. Хятадын засгийн газар санхүүгийн төсвийн тайлангаа 1978 оноос хойш Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хуралд өргөн барьж, батлан хамгаалахын зардлын урьдчилсан тооцооны нийт дүнгээ нийтэд зарладаг. Хятадын засгийн газар 1995 онд “Хятадын зэвсэг хянах ба зэвсэг хорогдуулах” цагаан номыг хэвлэж Хятадын батлан хамгаалах салбарын зардлын нөхцөл байдлыг дэлхий нийтэд зарласан. 2007 оноос хойш Хятад улс НҮБ-ын Цэргийн зардлын ил тод байдлын системд оролцож, жил бүр өмнөх санхүүгийн жилийнхээ батлан хамгаалах зардлын талаарх үндсэн мэдээллийг НҮБ-д өгдөг бөгөөд идэвхтэй хүч, нөөц хүч, цэрэг арми гэсэн гурван цэргийн ангиллын ажиллагсдын амьдрах зардал, сургалтын зардал, тоног төхөөрөмжийн зардал гэх гурван том зардлын нийт дүн, Батлан хамгаалах зардлын нийт дүн, Хятадын батлан хамгаалах зардлын гол хэрэглээ болон ДНБ-д эзлэх хувь хэмжээг тайлбарласан тайлбарыг мөн өгдөг.

Ерөнхийлөн үзэхэд Хятад улсын батлан хамгаалахын зардал нээлттэй, ил тод бөгөөд зардлын түвшин нь боломжийн, дэлхийн томоохон орнуудтай харьцуулахад батлан хамгаалах зардлын ДНБ ба төсвийн зардалд эзлэх хувь, нэг хүнд ногдох батлан хамгаалахын зардал харьцангуй бага байна. Хятад бол бүрэн нэгдэж хараахан

амжаагүй байгаа дэлхийн цорын ганц улс юм. Мөн түүнчлэн аюулгүй байдлын нөхцөл байдал хамгийн ээдрээтэй улсын нэг бөгөөд үндэсний бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, далайн эрхээ хамгаалах зэрэг хүнд сорилттой тулгардаг. Хятад улс дэлхийд эзлэх нөлөө нэмэгдэхийн хэрээр олон улсын хамтын нийгэмлэг Хятадын арми олон улсын нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулахыг хүсэмжилдэг болсон байна. Хятадын арми нь мэдээлэлжүүлэлтэд шилжих шатандаа явж байгаа бөгөөд дэлхийн шинэ цэргийн хувьсал өөрчлөлтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, Хятадын онцлогтой цэргийн өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх нь хүнд даалгавар болж байна. Үндэсний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, хөгжлийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгцээ шаардлага, их гүрний олон улсын үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх шаарлага, өөрийн улсын хөгжлийн баталгааг хангах шаардлага зэрэгтэй харьцуулахад Хятад улсын батлан хамгаалах зардал нь харьцангуй бага байна. Улсынхаа эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдуулан батлан хамгаалах зардлаа үргэлжлүүлэн тогтвортой нэмэгдүүлнэ.

ЗУРГАА. ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХУВЬ ЗАЯАНЫ ХАМТЫН ЦОГЦЫГ БАЙГУУЛАХАД ИДЭВХТЭЙ ҮЙЛЧИЛНЭ

Хүн төрөлхтний хувь заяаны хамтын цогцыг багуулахад энхтайван хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн улс бүрийн ард түмний нийтлэг ашиг сонирхлыг харгалзах хэрэгтэй. Хятадын цэрэг арми хүн төрөлхтний хамтын нийгэмлэгийн үзэл санааг тууштай хэрэгжүүлж, их гүрний цэргийн олон улсын үүрэг хариуцлагыг идэвхтэй биелүүлж, шинэ эрин үеийн олон улсын цэргийн хамтын ажиллагааг бүх талаар урагшлуулж, урт удаан хугацааны энх тайван, аюулгүй сайхан дэлхийг цогцлооход хувь нэмэр оруулахыг хичээдэг.

НҮБ-ын дүрэм болон зарчмуудыг тууштай баримтална

НҮБ-ын үүсгэн байгуулагч гишүүн улс, Аюулгүй байдлын зөвлөлийн байнгын гишүүн орны хувьд Хятад улс НҮБ-ын олон улсын үйл хэрэгт голлох үүрэгтэй оролцохыг дэмжиж, НҮБ-ын зорилго, зарчмыг үндэс болгон Олон улсын хууль, олон улсын харилцааны үндсэн зарчим, олон талт үзлийг баримталж, олон улсын харилцаанд ардчиллыг дэмжиж, дэлхийн аюулгүй байдлыг хангах зэвсгийн хяналт, зэвсэг хураах болон бусад салбарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож томоохон асуудлуудыг шийдвэрлэх, чухал дүрэм журам боловсруулахад хувь нэмэр оруулах болно. Хятад улс Солонгосын хойгийн асуудал, Ираны цөмийн асуудал, Сирийн асуудал зэрэг бүс нутгийн халуун цэгийн асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэхэд бүтээлчээр оролцож, гегемонизм, нэг талт байдал, давхар стандартыг эсэргүүцэж, аливаа асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг дэмжиж, НҮБ-ын аюулгүй байдлын зөвлөлийн тогтоолыг бүх талаар, тууштай хэрэгжүүлж байна. Хятад улс кибер орон зай, сансрын орон зай гэх мэт салбарын олон талт яриа хэлэлцээ, хэлэлцээрт идэвхтэй оролцож, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, шударга, үндэслэлтэй олон улсын дүрэм, журам боловсруулахыг дэмждэг. Хятад улс олон улсын зэвсгийн хяналт, зэвсэг хорогдуулах, дэлгэрүүлэхгүй байх хүчин чармайлтад идэвхтэй оролцож, зэвсгээр хөөцөлдөхийг эсэргүүцэж, дэлхийн стратегийн тэнцвэр болон тогтвортой байдлыг хамгаалж “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ»,

хийлийн цэргийн хяналт, зэвсэг хорогдуулах болон зэвсэг дэлгэрүүлэхийг эсэргүүцэх гэх мэт 10 гаруй гэрээнд гарын үсэг зурж нэгдэн орсон. 2015 онд Хятад улс 10 жилийн хугацаатай, нэг тэрбум ам.долларын өртөгтэй Хятад-НҮБ-ын Энхтайван, хөгжлийн санг байгуулж 2016 оноос албан ёсоор үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Эрх тэгш, харилцан итгэсэн, харилцан ашигтай шинэ хэлбэрийн аюулгүй байдлын түншлэлийн харилцааг дэмжих

Хятад улс гадаад улсуудтай цэргийн бүтээлч хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж бүх талын өргөн хүрээг хамарсан, олон түвшний цэргийн дипломат харилцааны шинэ хэв маягийг бий болгож байна. Хятад улс одоогоор 150 гаруй улстай батлан хамгаалах салбарын харилцаа үүсгэж 130 гаруй улсад цэргийн атташе байгуулж, 116 улс Хятадад цэргийн атташегаа байгуулж, 41 улс болон олон улсын байгууллагуудтай батлан хамгаалахын яриа хэлэлцээний механизм байгуулсан. 2012 оноос хойш Хятадын батлан хамгаалах салбарын өндөр дээд албан тушаалтнууд 66 гаруй оронд айлчилж 100 гаруй улсын батлан хамгаалахын сайд болон цэргийн командлагчид Хятадад айлчилсан.

Хятад Орос хоёр улсын цэргийн харилцааны өндөр түвшинд хүрч шинэ эринд хоёр орны хамтын ажиллагааны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ агуулгаар тасралтгүй баяжуулж буй нь дэлхийн стратегийн тогтвортой байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Хятад Орос хоёр улсын цэргийн бүх түвшний харилцааны механизм улам бүр сайжирч өндөр дээд түвшний харилцан айлчлал, цэргийн сургалт, техник тоног төхөөрөмжийн солилцоо, терроризмтэй тэмцэх зэрэг салбарт гүнзгий хамтын ажиллагаа өрнүүлж байна. Хятад, Оросын зэвсэгт хүчин 2012 оноос хойш долоон удаа стратегийн зөвлөлдөх уулзалт хийжээ. Оросын урилгаар Хятадын цэргийнхэн Оросын «Дорно дахины» стратегийн сургуулилтад 2018 оны 8-9 дүгээр сард анх удаа оролцов.

Сөргөлдөхгүй, зөрчилдөхгүй, харилцан хүндэтгэсэн, хамтран ажиллаж хамтдаа хожих зарчмаар АНУ-тай цэргийн харилцаагаа идэвхтэй зохистойгоор зохицуулж, хоёр орны цэргийн харилцааг хоёр улсын харилцааны тогтворжуулагч хүч болгон уялдаа холбоо, хамтын ажиллагаа, тогтвортой байдалд суурилсан Хятад Америкийн харилцаанд хувь нэмэр оруулна.

Хоёр улсын Батлан хамгаалах яам цэргийн томоохон үйл ажиллагаа явуулах тухай харилцан мэдэгдэх итгэлцлийн арга хэмжээний механизмыг бий болгож далай, агаарын аюулгүй байдлын үйл ажиллагааны зарчмын ойлголцлын санамж бичигт 2014 онд гарын үсэг зурсан. Хоёр тал “Цэргийн хямралын мэдэгдэл”, “Агаарт уулзах” гэсэн хавсралтыг шинээр нэмж оруулах талаар 2015 онд зөвшилцөлд хүрсэн. Хоёр улс гадаад харилцааны аюулгүй байдлын яриа хэлэлцээ, штабын хамтарсан яриа хэлэлцээний механизмыг 2017 онд байгуулж, стратегийн харилцаа холбоогоо идэвхтэй бэхжүүлж, аюул эрсдэлийн сөргөлдөөнөө зохицуулан хянах болсон. Хоёр тал Батлан хамгаалах яам, хуурай газрын, далайн, агаарын цэргийн армийн түвшинд яриа хэлэлцээний механизмыг хөгжүүлэн хүмүүнлэгийн тусламж, гамшгийн хор

уршгийг бууруулах, далайн дээрмийг эсэргүүцэх, эрдэм шинжилгээний солилцоо гэх мэт салбарт бодит хамтын ажиллагааг явуулж байна. АНУ-ын Тайваньд зэвсэг худалдах, Хятадын Цэргийн төв зөвлөлийн Тоног төхөөрөмжийн хөгжлийн газар болон тус газрын удирдлагад тавьсан хориг арга хэмжээ, Хятадын нутаг дэвсгэрт харьяалагдах далай болон агаарын орон зайд хууль бусаар нэвтрэх, тагнан турших үйл ажиллагаа явуулах гэх мэт өдөөн хатгасан үйл ажиллагааг Хятад улс эрс эсэргүүцэж байна. Хятад Америкийн харилцаан дахь хоёр улсын цэргийн салбарын харилцаа ерөнхийдөө тогтвортой байдлаа хадгалсаар ирсэн.

Хятад улс хөрш орнуудтайгаа хамтын цогц байгуулах үүднээс хөрш орнуудтайгаа цэргийн түншлэлийг бэхжүүлж байна

Хөрш орнуудынхаа цэргийн байгууллагуудтай дотно харилцаж, жил бүр цэргийн командлагчаас дээш түвшний хүмүүсийн 40 гаруй удаагийн айлчлал зохион байгуулж стратегийн харилцан итгэлцэл тасралтгүй нэмэгдэж байна. Хөрш 17 улстай батлан хамгаалах, аюулгүй байдлын яриа хэлэлцээ, ажлын уулзалт хийх механизмыг бий болгож харилцаа холбооны сувгуудыг нээлттэй болгосон. Сүүлийн жилүүдэд Хятад улс терроризмтэй тэмцэх, энхийг сахиулах, аврах ажиллагаа, цэрэг, цэргийн ур чадвар, тактикийн талаар цуврал хамтарсан сургуулилт, сургалтуудыг хөрш орнуудтайгаа тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд хил хамгаалах, эрэг орчмын хамгаалалт, боловсрол, сургалт, эмнэлгийн тусламж, тоног төхөөрөмж, технологи гэх мэт чиглэлээр практик хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, АСЕАН-тай батлан хамгаалах хамтын ажиллагааны түвшингээ тасралтгүй сайжруулж Хятадын хөрш орнуудтайгаа харилцах цэргийн харилцаа ерөнхийдөө тогтвортой байна.

Хятад улс Европын холбоотой цэргийн харилцаа идэвхтэй хөгжүүлж салбар бүрийн харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжлийн төлөвт байна. Хятад Европын холбоотой энх тайван, өсөлт хөгжил, шинэчлэл, соёл иргэншлийн түншлэлийг бий болгоход анхаарч аюулгүй байдлын бодлогын талаар яриа хэлэлцээ, далайн дээрмийн үйл ажиллагааны эсрэг хамтарсан сургалт, боловсон хүчний сургалтуудыг хийж байна. Хятад Европын холбоотой хамтран Хятад Европын холбооны аюулгүй байдлын бодлогын дээд түвшний семинарыг 2018 онд зохион байгуулсан.

Хятад улс Африк, Латин Америк ба Карибын тэнгис, Номхон далай гэх мэт бүс нутгийн хөгжиж буй улсуудтай цэргийн харилцаагаа бэхжүүлж цэргийн армиа бэхжүүлэх, батлан хамгаалах чадвараа сайжруулахад нь тусалж боловсон хүчний сургалт болон залуу офицеруудыг солилцоогоор явуулж байна. Бээжинд Хятад-Африкийн батлан хамгаалах, аюулгүй байдлын форум, Хятад-Латин Америкийн батлан хамгаалахын өндөр хэмжээний форум, Хятад-Карибын тэнгис, Өмнөд Номхон далайн орнуудын Батлан хамгаалахын удирдах албан тушаалтнуудын форум зэргийг 2018 онд зохион байгуулсан.

Хятадын арми харилцан итгэсэн, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчмыг баримталж дэлхийн улс бүрийн армитай ажил хэрэгч, хамтын ажиллагаа өрнүүлж байна. Хятад улс 2012 оноос хойш 30 гаруй улстай уламжлалт бус аюулгүй байдлаас уламжлалт аюул заналын хүрээнд, хилийн эргэн тойрны хүрээллээс холын далай тэнгис хүртэл тэлсэн 100 гаруй хамтарсан сургууль, сургалт явуулж тэдгээрт хуурай

замын цэргүүд төдийгүй тэнгисийн болон агаарын цэргийн хүчний бие бүрэлдэхүүн ч оролцсон.

Хятад улс боловсон хүчний сургалт, солилцоо, хамтын ажиллагааг идэвхтэй зохион байгуулдаг бөгөөд 2012 оноос хойш 50 гаруй улсад 1700 гаруй цэргийн оюутныг илгээсэн. 20 гаруй цэргийн академи нь 40 гаруй орны академиудтай харилцаа холбоо тогтоож 130 гаруй улсын 10 мянга гаруй цэргийн албан хаагчид Хятадын цэргийн академиудад ирж суралцсан.

2001 оны зургаадугаар сард Хятад улс Казахстан, Кыргызстан, Орос, Тажикистан, Узбекистантай Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг байгуулах санаачилга гаргасан. ШХАБ нь харилцан итгэлцэл, харилцан ашигтай, тэгш эрх, зөвлөлдөх, олон соёл иргэншлийг хүндэтгэх, хамтын хөгжлийг эрэлхийлэх, сурталчлах «Шанхайн хүсэл»-ийг бүрдүүлж, дэлхийн хамгийн өргөн цар хүрээтэй, хамгийн олон хүн амтай шинэ бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага болжээ. ШХАБ-ын хамтын нийгэмлэгийг байгуулж, олон улсын харилцааны шинэ хэлбэрийг урагшлуулж бүс нутгийн энх тайван хөгжил цэцэглэлтэд шинэ хувь нэмэр оруулсан.

ШХАБ 2017 оны зургаадугаар сард анх удаа гишүүнчлэлээ өргөжүүлж Энэтхэг болон Пакистан улс ШХАБ-ын гишүүн болсон. 2018 оны дөрөвдүгээр сард гишүүнчлэлээ өргөжүүлснээс хойших анхны батлан хамгаалах яамны сайд нарын уулзалт болсон. ШХАБ-ын гишүүн улсууд батлан хамгаалах аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа бэхжүүлж, «Энх тайвны үүрэг даалгавар» цуврал сургууль, «Энх тайвны уриа» цэргийн баярыг зохион байгуулж сайн хөршийн найрсаг стратегийн харилцан итгэлцлээ нэмэгдүүлж, цэргийн соёлын солилцоогоо өргөтгөж, гишүүн улсуудын эв найрамдлыг нэмэгдүүлсэн.

Хятад улс Ази тивийн улсуудын хамтран ажиллах, харилцан итгэсэн яриа хэлэлцээний механизм байгуулахыг дэмжиж, нийтлэг, цогц, хамтран ажиллах, тогтвортой Ази тивийн Аюулгүй үзэл баримтлалыг бий болгохыг санаачилж, Азид бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны бүтцийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

Хятад улс нээлттэй, хүртээмжтэй, ажил хэрэгч хамтын ажиллагааны зарчмыг дагаж АСЕАН-ны Батлан хамгаалахын сайд нарын өргөтгөсөн уулзалт, АСЕАН-ны бүс нутгийн форум, Шангрилагийн яриа хэлэлцээ, Жакартагийн олон улсын батлан хамгаалахын яриа хэлэлцээ, Баруун Номхон далайн бүсийн тэнгисийн цэргийн форум гэх мэт олон талт яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны механизм, Хятад-АСЕАН-ны Батлан хамгаалахын сайд нарын байнгын албан бус уулзалтад идэвхтэй оролцож бүс нутгийн батлан хамгаалахын аюулгүй байдлын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар бүтээлч санал дэвшүүлсэн. 2018 оны 10 дугаар сард “Хятад АСЕАН-ны далайн хамтарсан сургуулилт -2018”-ийг зохион байгуулсан нь Хятадын арми АСЕАН-ны армитай анх удаа далайн сургуулилт хамтран зохион байгуулсан явдал бөгөөд Хятад АСЕАН-ны орнууд бүгдээрээ энх тайван, тогтвортой байдлыг хамгаалахыг хүсэмжилж буйн илрэл болсон.

Хятад улс эрх тэгш, нээлттэй, хүлээцтэй, бие биенээ харилцан хянах үзэл санааг

дэмжиж Бээжингийн Сяншань форумыг байгуулсан. Сяншаны форумыг 2014 онд “Зам 1.5” олон улсын аюулгүй байдал, батлан хамгаалахын яриа хэлэлцээний платформ болгон өөрчилсөн. 2018 оны 10 дугаар сард болсон Сяншаний форумыг “Бээжингийн Сяншаний форум” гэж өөрчлөн нэрлэсэн бөгөөд 67 улс, долоон олон улсын байгууллагаас 500 гаруй төлөөлөгчид тус форумд оролцож бүс нутгийн аюул занал, сорилтыг даван туулах шинэлэг санаа, санаачилгын талаар ярилцаж, Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын яриа хэлэлцээ, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн.

Нутаг дэвсгэрийн асуудал болон усан хил хязгаарын маргааныг зүй зохистой шийдвэрлэх

Хятад улс ойр дотно, шударга, ашигтай, хүлээцтэй дипломат бодлого баримталж хөрш улсуудтайгаа найрсаг харилцаатай байж газар нутгийн асуудал болон далайн хил хязгаарын маргаантай асуудлаа яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлздэг.

Хятад улс хуурай газраар хиллэдэг 14 улсынхаа 12-той нь хилийн асуудлаа шийдвэрлэсэн бөгөөд найман улстай нь сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

Хятад улс санал зөрөлдөөнөө хянан удирдаж, харилцан итгэлцлээ нэмэгдүүлж эргэн тойрныхоо тогвортой байдлыг хамгаалахын тулд Хятад АСЕАН-ны батлан хамгаалахын сайд нарын байнга утсаар ярих механизмыг бий болгож, Вьетнам болон Өмнөд Солонгос улсын Батлан хамгаалах яамтай шууд утсаар холбогдох харилцааг тогтоож хуурай газраар хиллэдэг улсуудын армиудтай тогтмол болон тогтмол бус хугацаанд факс явуулж, утсаар ярих харилцааг бий болгож, хилийн хэлэлцээ, уулзалт, хамтарсан эрэл хайгуулын ажиллагааг зохион байгуулдаг.

2014 оноос хойш Хятад улс Вьетнамтай таван удаагийн хилийн дээд хэмжээний уулзалт хийсэн. Хятад Энэтхэг улсууд удирдагчдын яриа хэлэлцээний зөвшилцлийг хэрэгжүүлэхээр дээд түвшний айлчлал, яриа хэлэлцээний механизмыг бий болгож, хилийн хяналт, хамгааллын тогтолцоо, хилийн харилцан солилцооны механизмыг урагшлуулсан.

2016 оны сүүлийн хагас жилээс Хятад улс Филиппин улстай далайн аюулгүй байдлын яриа хэлэлцээ явуулж, хоёр тал Өмнөд Хятадын тэнгисийн асуудлыг яриа хэлэлцээний замаар зохицуулах зам руу эргэсэн. 2018 оны тавдугаар сард Хятад Япон улсуудын Батлан хамгаалах яамд далай болон агаарын холбоо харилцааны механизмын санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд зургаадугаар сараас тус механизмыг ажил хэрэг болгосон.

Хятад болон АСЕАН-ны орнууд «Өмнөд Хятадын тэнгис дэх талуудын үйл ажиллагааны тунхаглал»-ыг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлж, “Өмнөд Хятадын тэнгисийн үйл ажиллагааны зарчим” гэсэн зөвлөлдөх уулзалтыг идэвхтэй ахиулж, далай тэнгисийн аюулгүйн ажиллагааны бодит хамтын ажиллагааг нэмэгдүүлж, бүс нутгийн аюулгүй байдлын механизмыг ахиулж, Өмнөд Хятадын тэнгист энх тайван, найрамдалтай хамтын ажиллагааг бий болгохыг зорьж байна.

Олон Улсын нийтийн аюулгүй байдлыг хамгаалахад идэвхтэй оролцох

Хятад улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг идэвхтэй дэмжиж НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд томоохон хувь нэмэр оруулагчдын нэг бөгөөд Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн улсаас энхийг сахиулах ажиллагаанд хамгийн их цэрэг оруулсан улс юм. 2018 оны арванхоёр сар хүртэл Хятадын арми 24 төрлийн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож, 39 мянга гаруй энхийг сахиулагчдыг илгээж, 13 Хятад цэрэг энхийг сахиулах ажиллагааны фронтод амь үрэгдсэн.

Хятадын арми энхийг сахиулах ажиллагааны бүсэд 13 мянган гаруй км зам барьж, зассан, 10342 мина болон төрөл бүрийн дэлбэрээгүй тэсрэх бодисыг цэвэрлэж нэг сая 35 мянган тонн материалыг зөөж, нийт 13 сая гаруй км явсан. 170 мянга гаруй өвчтөнийг үзэн оношилж, харуул, урт болон богино эргүүл гэх зэрэг 300 гаруй ажлыг гүйцэтгэсэн.

Хятад улс 2015 оны есдүгээр сард НҮБ-ын энхийг сахиулах хүчний бэлэн байдлын механизмд орж 8000 цэрэг бүхий энхийг санхиулах бэлтгэл хүчийг байгуулав.

Хятад улс 2017 оны есдүгээр сард НҮБ-ын энхийг сахиулах бэлэн байдлын армийн анхан шатны бүртгэлийн ажлыг хийсэн. Эхний түвшний 13 баг НҮБ-ын шалгалтыг . 2018 оны 10 дугаар сард өндөр үнэлгээтэй давж, хоёр дахь байдлын бэлэн байдлын статусд шилжсэн. НҮБ дээр дурдсан 13-II зэрэглэлийн бэлэн байдлын багаас тавыг нь III зэрэглэлд 2019 оны хоёрдугаар сард шилжүүлсэн. Хятад улс олон улс орнуудад энхийг сахиулагчдыг идэвхтэй бэлтгэдэг бөгөөд одоогийн байдлаар арав гаруй оронд 1500 гаруй энхийг сахиулагчдыг бэлтгэжээ. Хятад цэргийн 2506 албан хаагчид НҮБ-ын долоон үүрэг гүйцэтгэх бүс болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны газарт 2018 оны арванхоёрдугаар сард үүрэг гүйцэтгэв.

НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн холбогдох тогтоолын дагуу Хятадын Засгийн газар 2008 оны 12 дугаар сард Адены булан ба Сомалийн усан хилрүү байнгын хамгаалалтын ажиллагаанд тэнгисийн цэргийн флотоо илгээсэн бөгөөд олон улсын хамгаалалтын хүчнүүдтэй хамтран ажиллаж, олон улсын далай дээрх хоолойн аюулгүй байдлыг хамтран хамгаалсан.

Арван жилийн хугацаанд Хятадын тэнгисийн цэргийн хүчин 3-4 хөлөг онгоц байнга байрлуулан хамгаалах үүрэг гүйцэтгэж, 31 бүлэг 100 гаруй хөлөг онгоц илгээж, 26000 гаруй цэрэг 6600 гаруй хятад ба гадаадын онгоцны аюулгүй байдлыг хамгаалж 70 гаруй аюулд өртсөн усан онгоцыг аварсан.

Хятадын арми олон улсын гамшгаас аврах, хүмүүнлэгийн тусламжийн ажилд идэвхтэй оролцож, гамшигт нэрвэгдсэн улс орнуудад гамшгаас аврах мэргэжлийн аврах хүчийг илгээж, эмнэлгийн тусламж үзүүлж гамшгаас аварч туслах олон улсын солилцооны ажлыг эрчимжүүлж байна. 2012 оноос хойш сураггүй болсон Малайзын иргэний агаарын тээврийн МН370 онгоцыг эрэн хайх, аврах ажиллагаа, Филиппин дэх Хайян хар салхинаас аврах ажиллагаа, Баруун Африк дахь Эбола тахлын эсрэг тэмцэх ажиллагаа, Мальдив дахь усны дутагдлаас аврах ажиллагаа, Непал дахь газар хөдлөлтийн гамшиг, Лаост болсон үерийн гамшиг гэх мэт олон аврах ажиллагаанд оролцсон. Хятадын тэнгисийн цэргийн «Энх тайвны ихэр завь» эмнэлгийн хөлөг

онгоц 10 жилийн турш долоон удаа авран туслах үүрэг гүйцэтгэж, 43 улсад зочилж 230 гаруй хүнийг эмчилсэн.

Хятад Улс олон улсын болон бүс нутгийн терроризмын эсрэг хамтын ажиллагааг идэвхтэй явуулж байна

ШХАБ-ын хүрээнд олон улсын терроризмын эсрэг хамтын ажиллагааг бэхжүүлж, терроризмын эсрэг хамтарсан сургууль, хууль бусаар зэвсэг, сум болон тэсрэх бодис зөөвөрлөхтэй тэмцэж, тагнуулын ажиллагааг шалган тогтоож, таслах чиглэлээр олон улсын терроризмын эсрэг нууц мэдээллийг солилцох, хуваалцах байдлыг урагшлуулж байна. Терроризмын эсрэг үйл ажиллагааг гол болгосон “Цагаан хэрэм” олон улсын форумыг зохион байгуулж, АПЕК-тай хамтран зохион байгуулсан терроризмын эсрэг ажлын хэсэг болон олон улсын терроризмын эсрэг олон талт механизмд идэвхтэй оролцож байна. Зарим улстай терроризмын эсрэг хоёр талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Афганистан, Хятад, Пакистан, Тажикистан дөрвөн улстай терроризмын эсрэг хамтын ажиллагааны зохицуулалтын механизмыг бий болгохыг дэмжиж хоёр улсын армийн өндөр албан тушаалтнуудын хурлыг зохион байгуулж, терроризмын эсрэг хамтын ажиллагааг эхлүүлж бүс нутгийн аюулгүй байдлыг идэвхтэй хамгаалж байна.

Дүгнэлт

Энх тайван бол улс бүрийн ард түмний нийтлэг хүсэл, хөгжил бол хүн төрөлхтний нийгмийн өнө мөнхийн гол сэдэв юм. Өдөр ирэх бүр ээдрээтэй болж буй дэлхийн аюулгүй байдлын сорилтууд, хүн төрөлхтөний хөгжил хаашаа явах вэ гэсэн гол сонголттой тулгарч буй өнөө үед Хятад улс гегемонизмын тэлэлт эцэстээ бүтэлгүйтэж, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийнхээ арга туршлагыг хамтдаа хуваалцах ёстой гэдэгт бат итгэлтэй байна. Хятад улс нь энх тайван хөгжлийн замаар тууштай замнаж, дэлхийн энх тайвныг хамгаалж, хамтын хөгжлийг ахиулахын төлөө бүх орны ард түмэнтэй хамтарч ажиллах болно.

Шинэ эрин үеийн Хятадын батлан хамгаалахын салбар Си Зиньпиний армиа хүчирхэгжүүлэх үзэл санааг удирдлага болгож Хятадын онцлогтой хүчирхэг арми байгуулах замаар замнаж, дэлхийн тэргүүний арми байгуулах агуу зорилгодоо хүрэхийн тулд зоригтой урагшилж байна. Хятад үндэстний агуу их сэргэн мандалтыг бий болгох Хятад мөрөөдлөө биелүүлэхэд стратегийн дэмжлэг үзүүлж, хүн төрөлхтний хамтын цогцыг бий болгоход хувь нэмэр оруулахын тулд Хятадын арми ямарч аюул занал, сорилтыг давж гарах итгэл найдвар төгс байна.